

9. ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ (Ж-5.3, Х-3-3.1)

БСШУЯ-ны 5 ангийн 12 бүтээгдэхүүнийг 91 хувиар, ЭМЯ-ны 6 ангийн 15 бүтээгдэхүүнийг 90 хувиар, БХЯ-ны 4 ангийн 17 бүтээгдэхүүнийг 95 хувиар, Тэргүүн шадар Сайдын 5 ангийн 5 бүтээгдэхүүнийг 95 хувиар, Шадар сайдын 12 ангийн 384 бүтээгдэхүүнийг 92 хувиар, НХХЯ-ны 5 ангийн 41 бүтээгдэхүүнийг 89 хувиар, ХЗДХЯ-ны 5 ангийн 31 бүтээгдэхүүнийг 90 хувиар, БОАЖЯ-ны 4 ангийн 4 бүтээгдэхүүнийг 89 хувиар, Үндэсний статистикийн хорооны 4 ангийн 17 бүтээгдэхүүнийг 90 хувиар, ХХААХҮЯ-ны 5 ангийн 16 бүтээгдэхүүнийг 89 хувиар тус тус биелүүллээ. Нийт Яам, тусгай газрын нийт 55 ангийн 542 бүтээгдэхүүнийг дундаар 91 хувиар биелүүлсэн байна.

3.1.1.Боловсрол соёл шинжлэх ухааны Яам

Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын 75 нэгж байгууллагын үйл ажиллагаагаар дамжуулан аймгийн хүн амд боловсрол,соёл,шинжлэх ухааны үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 27, аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 21 заалт, аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2009 оны 19 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаа.

2009 онд улсын хөрөнгө оруулалтын 3011.7 сая төгрөгийн санхүүжилтээр 18 барилгыг, " тогтвортой амьжиргаа" төслийн санхүүжилтээр 11 соёлын төвд 61.3 сая,12 сургуульд 110.8 сая, 17 цэцэрлэгт 65.2 сая төгрөгийн засвар тохижилтын ажлыг тус тус хийлээ.

Аймгийн хэмжээнд 2009-2010 оны хичээлийн жилийн мэдээгээр 2-5 хүртэлх насны 6320 байгаагийн 4960 буюу 78,4 хувийг сургуулийн өмнөх боловсрол олгох сургалтанд хамруулснаас 3001 хүүхдийг цэцэрлэгийн үндсэн бүлгийн сургалтаар,1959 хүүхдийг хувилбарт сургалтанд хамруулсан байна.

Аймгийн 18 суманд нийт 36 гэр цэцэрлэгийн бүлэг ажиллуулж 2010 оны хичээлийн жилд сургуульд элсэн суралцах 5 настай 513 хүүхдийг гэр цэцэрлэгээр, ээлжийн бүлэгт 205, явуулын багшийн сургалтаар 89, үндсэн бүлгийн сургалтаар 899 хүүхдийг сургаж 100% хамруулав.

Боловсролын стандарт тогтоох явцад ажлын байрны тодорхойлолтод заагдсан багшийн ажлын үндсэн чиг үүрэг, зорилго, гол үйл ажиллагааны хүрээнд хийгдэх зорилтууд, хариуцлага, тухайн ажлын байранд тавигдах үндсэн болон тусгай шаардлагуудыг хэрхэн биелүүлж байгааг тогтоох үүднээс тусгай боловсруулсан шалгуур үзүүлэлтийн дагуу 25 цэцэрлэгийн 88 багш, аймгийн төвөөс бусад сургуулийн 572 багшид ажлын байрны тодорхойлолтын дагуу үнэлгээ өглөө.ЕБС-ын болон СӨБ-ын сургалт хүмүүжлийн ажил, хамран сургалт, үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, сургалт хүмүүжлийн ажил хэвийн төвшинд явагдаж байна гэсэн дүгнэлт хийлээ.

Энэ хичээлийн жилд Баруунтуруун сумын ахлах сургуульд 50 хүүхдийн, Өлгий сумын ахлах сургуульд 80 хүүхдийн, Зүүнговь сумын ахлах сургуульд 100 хүүхдийн дотуур байр

шинээр баригдаж, Бөхмөрөн сумын дунд сургууль 60 хүүхдийн дотуур байрыг засварлаж ашиглалтанд оруулснаар дотуур байрны багтаамж аймгийн хэмжээнд нийт 290 ороор нэмэгдлээ.

Элсэлтийн ерөнхий шалгалтанд нийт 1355 шалгуулагч орж 5773 шалгалт өгч, нэгдсэн дүнгээр 507.5 дундаж оноо авч улсад 3-р байр эзэллээ.

Тариалан сумын цэцэрлэг улсын тэргүүний цэцэрлэгээр шалгарч, улсын олимпиадаас 4 багш, 2 сурагч медаль авлаа.

Соёлын төвүүдийн номын сангийн фонд нийт 8362620 төгрөгийн 1244ш/Азийн хөгжлийн сангаас 160ш ном, ард иргэдийн хандиваар 20ш ном/ номоор баяжигдсан. Төвийн номын сан 346-н нэр төрлийн 568ш 4287527 төгрөгийн ном, хэвлэлээр фондоо баяжуулж, тогтмол хэвлэлийн танхимын тоог шинээр нэмэгдүүлж өмнөх оноос 5-аар нэмэгдүүлсэн. 2009 онд 18-н сумдын соёлын төвүүдийг үндэсний найрал хөгжмийн зэмсэг, даралтат хөгжим, өндөр хүчин чадалтай аппаратураар хангаж, тэдний үйл ажиллагааны хүрээг өргөжүүлж, иргэдэд үйлчлэх үйлчилгээг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Бүх сумдын үл хөдлөх дурсгалын видео бичлэг, гар тэмдэглэл, түүх соёлын дурсгалт зүйлийг судалж тодорхойлох, хамгаалах дурсгалыг очиж үзээд бүртгэж картлах, ардын урлагийн наадмын аудио, болон видео бичлэг, аймгийн мэргэжлийн урлагийн байгууллагын уран бүтээлүүдийн видео бичлэг, музей, номын сангуудын видео бичлэг, Их монгол улс байгуулагдсаны 803, Ардын хувьсгалын 88 жилийн ойн арга хэмжээнүүдийн тоглолтын бүрэн бичлэг фото зургын хамт тус тус төвлөрч үндсэн фонд сан хөмрөгийн баялаг судалгааг бий болгоод байна.

Энэ онд 5 ангийн 12 бүтээгдэхүүний дундаж биелэлт 91 хувьтай байна.

3.1.2.Тэргүүн шадар Сайдын бүтээгдэхүүн

Аймгийн Засаг даргын Тэргүүн шадар Сайдтай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээгээр Хэмжүүр баталгаажуулалт, Чанарын сорилын шинжилгээ, Стандартчилал, тохирлын үнэлгээ гэсэн 3 ангийн 15 нэрийн бүтээгдэхүүнийг 67728.3 мянган төгрөгийн өртөгтэйгээр үйлдвэрлэж нийлүүлэх, улсын төсөвт 7000.0 мянган төгрөг оруулж баталгаажуулсан хэмжих хэрэгслийн тоо, сорилт шинжилгээ хийсэн бүтээгдэхүүний дээжийн тоо, тохирлын тэмдэгтэй бүтээгдэхүүн, бүртгэсэн байгууллагын стандарт, стандартын борлуулалтын орлого зэрэг бүх үзүүлэлтийг 100.0-110.0 хувиар биелүүллээ.

Аймгийн хэмжээгээр хэмжих хэрэгслийн баталгаажуулалт хийх хуваарь гарган баталгаажуулалтын графикт тусгагдсаны дагуу 2 удаагийн баталгаажуулалтыг механик, цахилгаан, эзэлхүүн багтаамжийн төрлөөр нийтдээ 7771 хэмжих хэрэгсэлд баталгаажуулалт хийснээс Дэлхийн банкны төслөөр хэрэгжиж байгаа Улаангом сумын гэр хорооллын цахилгаан дамжуулах шугамыг шинэчлэх төслийн хүрээнд шинээр суурилагдсан 6778 ширхэг тоолуур, механик цулын эталон, туухай зэрэг 40 ажлын эталон баталгаажууллаа.

Чанарын сорилтын шинжилгээг 1427 дээжид шинжилгээ хийлээ. Чанарын баталгаажуулалтанд 119 аж ахуйн нэгж байгууллагыг, экспортын 3, дотоодын 15 нэрийн бүтээгдэхүүнд, үйлчилгээний 68 газарт тохирлын үнэлгээ хийлээ.

Тэргүүн шадар Сайдын 5 ангийн 5 нэрийн бүтээгдэхүүнийг 95 хувь гэж үнэллээ.

3.1.3. Шадар Сайдын бүтээгдэхүүн

Увс аймгийн Засаг дарга, аймгийн Хүүхдийн төлөө хэлтсийн даргын хооронд Хүүхдийн хөгжил, хамгааллын асуудлаар 3 бүтээгдэхүүн ангийн хүрээнд хүүхдийн эрх, хамгааллыг сайжруулж, хууль тогтоомж, шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих хүүхдийн хөгжил оролцоог хангах, хүүхдийн эрх хамгааллын асуудлаар бүх шатны байгууллагын ажилтнуудыг чадваржуулах, иргэд олон нийтийн хандлагыг өөрчлөх, байгууллагын орчин нөхцлийг сайжруулж “Хүүхдэд ээлтэй орчин” бүрдүүлэх, хүүхдийн холбогдолтой хууль, тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулах, Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцыг хэрэгжүүлэх чиглэлийн нийт 16 бүтээгдэхүүн худалдан авахаар талууд харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулсныг үндэслэн гэрээний биелэлтийг гаргаж хүргүүлэв.

Увс аймгийн Засаг дарга, аймгийн Онцгой байдлын хэлтсийн даргын хооронд гамшгаас хамгаалах асуудлаар 4 ангийн 20 бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний хүрээнд аймгийн 19 суманд сумын онцгой байдлын орон тооны бус штаб, ерөнхий зориулалтын сумын шуурхай команд, аймгийн төвд гамшгаас хамгаалах 11 албад, 7 аж ахуйн нэгж байгууллагыг түшиглэн тусгай зориулалтын 3 мэргэжлийн анги, отряд, 12 бүлэг, 6 хэсэг, Хөдөлмөрийн дээд сургуулийн салбар, Улаангом коллеж, ерөнхий боловсролын цогцолбор сургууль, ахлах сургууль, сумдын дунд сургууль, хүн эмнэлэг зэрэг 58 албан газруудыг түшиглэн эмнэлгийн анхны тусламжийн нөхөрлөлийг байгуулж 2133 томилгоот бүрэлдэхүүнийг томилгоожуулан холбогдох үүрэг чиглэлийг өгч ажиллалаа.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2006 оны 162 дугаар тушаалын хавсралтын дагуу аймгийн Онцгой байдлын хэлтсийн ажлын албыг 13 албан хаагчтайгаар, гал унтраах ангийг 29 албан хаагчтайгаар, гал унтраах ангийн бүтэц дотор эрэн хайх аврах бүлгийг 6 албан хаагчтайгаар бүгд 48 албан хаагчийн орон тоотойгоор шинэчлэн зохион байгуулсан.

Аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд 2009 оны 1 сард багтаан нэмэлт өөрчлөлт оруулсан. Тухайлбал, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангиуд, сумын шуурхай командуудын хүч хэрэгслийн тооцоо, сум, багийн судалгаа, хүн амын тоо, Онцгой байдлын хэлтсийн хүч хэрэгслийн судалгаа, аймгийн мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл зохион байгуулалт, өвөлжих хаваржих малын хашааны тоо, худаг уст цэгийн тооцоо, жилийн эцсийн нийт малын тоо, тэжээвэр амьтдын судалгаа, гамшгийн үед дайчлан ажиллуулах автомашин, техник хэрэгслийн судалгаа, өөр аймгийн нутагт отроор өвөлжих хүн малын судалгаа, өөрийн аймгийн бусад сумын нутагт отроор өвөлжих хаваржих хүн малын судалгаанд тус тус нэмэлт оруулж тодотгол хийсэн.

Аймгийн хэмжээний бүх сум, албад, аж ахуйн нэгж байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт тодотгол хийх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Энэ оны 11 сард аймгийн хэмжээнд томуугийн цартахлын онцгой байдлын үед авч хэрэгжүүлэх бэлэн байдлын төлөвлөгөөг 5 зүйл, 52 заалттайгаар боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулсан.

Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай, Төрийн албаны тухай хууль, Төсвийн байгууллага удирдлага, санхүүжилтын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, 2009 онд ирүүлсэн Засгийн газрын 3 тогтоол, 2 албан даалгавар, Монгол Улсын Шадар сайдын баталсан 10 удирдамж, Улсын Онцгой комиссын 1 албан даалгавар, 4 хурлын тэмдэглэл, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2 албан даалгавар, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 7 тушаал, Онцгой байдлын ерөнхий газрын 8 даргын удирдамж, аймгийн Засаг даргын 5 албан даалгавар, 14 захирамж, зөвлөлийн хурлын 2 тэмдэглэлийн хэрэгжилтэнд хяналт тавьж, биелэлтийг заалт нэг бүрээр гаргаж үр дүнг нь хагас, бүтэн жилээр тооцон ажилласан.

Аймгийн Онцгой байдлын хэлтэс нь төрийн холбооны сувагтай. Интернетийн сүлжээнд холбогдсон. Сансрын холбооны IRIDIUM гар утас 1, богино долгионы BARRET-2050 станц 1, богино долгионы ICOM-78 станц 3, богино долгионы үүргэвчтэй CODAN-2110 станц 1, хэт богино долгионы YAESU гар станц 5, хэт богино долгионы MOTOROLA маркийн гар станц 10, байрлал тогтоогч 3-ыг тус тус ашиглаж байна. Техник хэрэгслийн тухайд notebook 4, пентиум-4 компьютер 6, принтер 5, хувилагч 2, факсын аппарат 2 ширхгийг өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна.

Онцгой байдлын ерөнхий газартай интернетийн сүлжээгээр холбогдон үйл ажиллагаагаа зохион байгуулж байгаа. Өдөр тутам Barret-2050 болон ICOM-78 маркийн богино долгионы станцаар холбоонд орж мэдээ мэдээлэл дамжуулж байна. Тухайлбал, Онцгой байдлын ерөнхий газарт гамшиг ослын нөхцөл байдлын тухай мэдээ 56, радио холбоогоор хоногийн нөхцөл байдлын тухай мэдээ 865, Онцгой байдлын ерөнхий газарт хүн, хүч хэрэгслийн хоногийн мэдээг интернетээр 358, бусад мэдээ мэдээллийг давхардсан тоогоор 65 удаа хүргүүлсэн. Мэдээллийн технологийг нэвтрүүлэх ажлын хүрээнд байгууллагын бүх компьютеруудыг дотоод сүлжээ болон интернетэд холбон үйл ажиллагаагаа хэвийн хэмжээнд явуулж байна. Аймгийн хэмжээнд сүүлийн 30 гаруй жилд тохиолдсон гамшгийн мэдээ мэдээллийг цуглуулж мэдээллийн сан бий болгох ажлыг хийж байна.

2009 онд Тариалан, Ховд, Завхан, Улаангом зэрэг 4 сум, 11 гамшгаас хамгаалах албадад гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулж явуулсан. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгт давхардсан тоогоор 38 албан газар, 26 аж ахуйн нэгж байгууллага болон 177 албан тушаалтан хамрагдсан.

2009 онд 11 сум, 11 гамшгаас хамгаалах албад, 12 албан газар, аж ахуйн нэгж байгууллагуудад “Гамшгаас хамгаалах зарим арга хэмжээг зохион байгуулах нь” сэдвээр 136 цагийн хичээл сургалтыг зохион байгуулсан.

Улаангом сумын төвийн 9 багийн ард иргэдийн төлөөлөл 540 гаруй иргэд, гал унтраах ангийн тактик тусгай сургуулийн явцад 5 албан газар, аж ахуйн нэгж байгууллагын 132 ажилтан, албан хаагчдад, гал унтраах ангийн салаадын тархалтын сургууль явуулах үед 48 албан газар, аж ахуйн нэгж байгууллагын 2880 ажилтан, албан хаагчдад бүгд 56 цагийн сургалт явуулж урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан.

Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 7 захирамж, 4 албан даалгавар, Онцгой байдлын хэлтсийн даргын баталсан 12 ажлын удирдамж, сум,

албан газар, аж ахуйн нэгж байгууллагуудад 7 албан бичиг зэрэг удирдлагын баримт бичиг төлөвлөн хэрэгжилтэнд нь хяналт тавьж үр дүнг тооцон ажиллаж ирсэн. Сум, баг, ард иргэдэд цаг агаарын болзошгүй нөхцөл байдлын тухай 21 сэрэмжлүүлэх мэдээ мэдээллийг аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний албаны өртөө харуулууд болон орон нутгийн МВС, САМА телевизээр дамжуулан тухай бүр нь мэдээлж байсан.

Аймгийн Онцгой байдлын хэлтсийн ажлын байранд гамшгаас хамгаалах удирдлагын бүрэлдэхүүний сургалтын танхимыг шинээр байгуулсан. Сургалтын танхимыг тохижуулахад “Шувууны томуу, хүний томуугийн цартахалтай тэмцэх чадавхийг сайжруулах” төслийн багаас 5 нэр төрлийн 6.013.4 мянган төгрөгийн сургалтын тоног төхөөрөмжийн дэмжлэг тусалцаа үзүүлсэн.

Аймгийн Засаг даргын зүгээс онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчдын сургалтыг зохион байгуулахад 2.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Аймгийн хэмжээнд үүссэн гамшгийн үед шуурхай удирдлагаар хангах ажлын хүрээнд Онцгой байдлын хэлтэс дээр аймгийн Онцгой комиссын гишүүд, удирдах бүрэлдэхүүн, сум, албад, албан газар, аж ахуйн нэгж байгууллагын албан тушаалтнуудын ажлын болон гар утас, гэрийн утасны жагсаалтыг нэг бүрчлэн гаргаж нэмэлт өөрчлөлт хийж ажиллаж байна.

2009 оны 9 сард Онцгой байдлын ерөнхий газрын Авто баазаасирүүлсэн ГАЗ-66 маркийн автомашиныг ашиглан хээрийн удирдлагын хөдөлгөөнт байр хийх талаар тоноглох хөрөнгө зардлын тооцоог хийгээд байна. Хээрийн удирдлагын ажлын болон бусад зориултаар 3 асар, 4х4 платак 1 ширхгийг бэлтгэсэн байгаа.

Гамшгийн голомтонд онцгой байдлын байгууллагын албан хаагчдын үүрэг гүйцэтгэх чадавхийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2009 онд ОХУ-ын Эрхүү мужид зохион байгуулж явуулсан сургалтанд 2, Онцгой байдлын ерөнхий газраас явуулсан удирдах ажилтны сургалтанд 1, жолооч, аврагч бэлтгэх сургалтанд 6, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд явагдсан сургалтанд давхардсан тоогоор 5, нийт 14 албан хаагч хамрагдсан.

Онцгой байдлын ерөнхий газрын дарга, гамшгаас хамгаалах улсын хяналтын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу 58 албан газар, аж ахуйн нэгж байгууллагуудад гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх нэгдсэн шалгалт хийж 92 зөрчил илрүүлж 68 зөрчлийг засуулж, 24 зөрчлийг засуулахаар гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн албан шаардлага хүргүүлж хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажилласан.

2009 онд ой, хээрийн түймэр 2, объектын гал түймэр 15 удаа гарсныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ой, хээрийн түймрийн тоо 70%, объектын гал түймрийн тоо 50%, гал түймрийн улмаас учирсан хохирлын хэмжээ 50%-аар тус тус буурсан тоон үзүүлэлттэй байна.

Аймгийн Онцгой комиссоос хүргүүлсэн саналын хүрээнд Улсын Онцгой комиссын шийдвэрээр тус аймгийн Баруунтуруун, Өмнөговь сум дахь Улсын нөөцийн салбар, цэгүүдэд 60 тонн өвс, 40 тонн тэжээлийг тээвэрлэн хүргүүлсэн.

Аймгийн гамшгаас хамгаалах сангаас хаваржилт хүндэрсэн 9 суманд Улаангом сум дахь Улсын нөөцийн салбараас 7.626.2 мянган төгрөгийн өвс тэжээл, тээврийн зардалд 6.732.8 мянган төгрөгийг тус тус гаргаж тээвэрлэлтийг зохион байгуулсан.

Өвөлжилт, хаваржилт хүндэрсэн 10 суманд нийт 60 гаруй албан газар, аж ахуйн нэгж байгууллагаас өвс, тэжээл, бензин, шатахуун, хоол хүнс, хувцас, эм тариа зэрэг эд материалын бүгд 17.554.885 төгрөгийн дэмжлэг тусламж үзүүлсэн.

2009 оны 3 дугаар сард Түргэн, Сагил, Улаангом, Тариалан зэрэг 4 сумын нутгаар их хэмжээний цас орж мал хаваржилт хүндэрч хаврын нүүдэл хийж байсан олон тооны мал цас зудын аюулд өртсөн. Үүссэн цагийн байдалтай холбогдуулан аймгийн гамшгаас хамгаалах сангаас 10.664.550 төгрөгийг гарган зарцуулсан.

“Дэлхийн зөн” олон улсын байгууллагаас 8 сумын 41 багийн 4590 малчин өрхөд нийт дүнгээр 15000 орчим долларын өртөг бүхий гурил, малын тэжээлийн тусламж дэмжлэг үзүүлсэн.

Увс аймгийн орон нутгийн гамшгийн нөөц нь өвс, тэжээл байна. Аймгийн Онцгой комиссын нөөцөнд 97.5 тн тэжээл, 100 тн өвс нөөцийг бүрдүүлсэн байгаа. Аймгийн Онцгой комиссын дансанд 10.0 сая төгрөгийн бэлэн мөнгөний нөөцтэй. 9.0 сая төгрөгийн хувцас хэрэгслийн эргэлтийн хөрөнгийн нөөц байна. Сумдад 300.0-500.0 мянган төгрөгийн нөөц бүрдүүлсэн.

Онцгой байдлын ерөнхий газраас 2009 онд болзошгүй гамшгийн үед хойшлуулшгүй арга хэмжээний чадамжийг сайжруулахад зориулж хангалтаар УАЗ-22069-33 маркийн пургон, ГАЗ-66 маркийн автомашинуудыг хүлээн авсан.

Улсын Онцгой комисс, Засгийн газрын шийдвэрээр Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Улаангом дахь Улсын нөөцийн салбарт 370 тн тэжээл, 250 тн өвс, Өмнөговь сум дахь улсын нөөцийн цэгт 260 тн тэжээл, 300 тн өвс, Баруунтуруун сум дахь Улсын нөөцийн салбарт 218 тн тэжээл, 300 тн өвс, нийт дүнгээр 848 тн тэжээл, 850 тн өвс нөөцийг байршуулсан.

Аймгийн Засаг даргын зүгээс Онцгой байдлын хэлтсийн үйл ажиллагааны бэлтгэл бэлэн байдлыг тасралтгүй хангахад дэмжлэг үзүүлж суудлын автомашин худалдан авахад 10.0 сая төгрөг шийдвэрлэж өгсөн.

“Шувууны томуу, хүний томуугийн цартахалтай тэмцэх чадавхийг сайжруулах” төслийн багаас 2 нэр төрлийн 4928.0 мянган төгрөгийн лабораторийн хэрэгсэл болон нэг удаагийн иж бүрдэл хувцас зэргээр материаллаг дэмжлэг үзүүлсэн.

2009 онд төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийг 5 албан хаагчид олгосон. 14 албан хаагч, 1 өндөр настанд бүгд 660.0 мянган төгрөгийн дэмжлэг тусламж үзүүлсэн.

Хэлтсийн албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах ажлын хүрээнд нэг давхрын коридорт 96.8 м² гантиг чулуун шал хийхэд 2598.0 мянган төгрөг, ээлжийн албан хаагчдын хооллох өрөөнд 12 м² паркет шал хийхэд 105.0 мянган төгрөг, гал тогооны өрөөний засварын ажилд 62.0 мянган төгрөг, гадна орчинд 12 ширхэг чацарганы модны суулгац тарих, түүнийг хамгаалах хашаа саад барихад 297,0 мянган төгрөг, байгууллагын гадна талын хашаа саад, сүүдрэвч, автомашны зогсоолын хэсгийг шинээр будах, хооллох өрөөнд 7 ширхэг сандал

шинээр хийх, шинэ хаалга хийх, цонх шиллэх, сантехникийн зарим хэсгүүдийг сольж засварлах ажил зэрэгт нийт дүнгээр 3768.1 мянган төгрөгийн бүтээлч ажлыг хийсэн байна.

Албан хаагчдын хүнсний хэрэгцээнд зориулж 0.4 га талбайд 4 нэр төрлийн хүнсний ногоо тариалж 1.3 тонн ногоо хураан авсан.

Бие бүрэлдэхүүний чөлөөт цаг, идэвхтэй амралтыг зохион байгуулахад туслах аж ахуйгаас 6 хонь, 182.0 мянган төгрөгийн бензин зарцуулсан.

Тус аймаг дахь ХААН банктай гэрээ байгуулан ажилласны үр дүнд давхардсан тоогоор нийт 60 албан хаагчид урт богино хугацааны цалингийн зээл олгосон байна.

2009 оны 9 дүгээр сард явагдсан архив албан хэрэг хөтлөлтийн үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд хэлтсийн архивын өрөөг тохижуулж тавиурыг стандартын дагуу хийсэн. Тус хэлтсийн архивт 15 нэр төрлийн 32 хавтас байнга, 111 хавтас түр хадгалагдах баримт бичиг хадгалагдаж байна. Гал түймэртэй тэмцэх хэлтэс ажиллаж байгаад цомхотголоор халагдсан 6 иргэнд архивын лавлагаа гаргаж өгсөн.

МХГ-ын 2009 оны үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, чанар, үр дүнг тайлагнавал: үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл 93.5 хувьтай байна. Энэ дүнд гэрээнээс гадуур нийлүүлэгдсэн бүтээгдэхүүний гүйцэтгэл орсон. Гэрээнээс гадуур нийлүүлэгдсэн бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өргөдөл хүсэлт, гомдол мэдээллийн мөрөөр хийгдсэн хяналт шалгалт болон ажлын зайлшгүй шаардлагаар хийсэн гүйцэтгэлийн хяналт шалгалтууд болно. Гэрээнээс гадуур бүтээгдэхүүн нийлүүлэх болсоны шалтгаан нь төсөв хөрөнгийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан тухайн төлөвлөсөн сумаас өөр суманд тухайн хяналтын чиглэлээр хяналт шалгалтыг хийсэн, түүнчлэн ААНБ, иргэдийн хүсэлтийг хэрэгжүүлэхтэй холбогдон уг бүтээгдэхүүнийг зайлшгүй нийлүүлэх шаардлага гарсан болно.

Тайлант хугацаанд төлөвлөсөн хэмжээнд ажил гүйцэтгэгдээгүй болон огт хийгдээгүй байгаа ажлын шалтгаан нь төсөв хөрөнгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан сумдад хийгдэх зарим хяналт шалгалт хугацаандаа хийгдээгүй болон зарим хяналтын байцаагчид /Орчны эрүүл ахуй халдвар судлалын хяналт, Барилгын техникийн хяналт, Хүүхдийн эрүүл ахуйн хяналт гэх мэт/ байхгүйгээс хяналт шалгалт хийгдээгүйтэй холбоотой зөрүү гарсан болно.

МХЕГ-аас ирүүлсэн удирдамж болон 2009 онд орон нутагт хийгдэх хяналт шалгалтын ажлын график төлөвлөгөөний дагуу хийсэн шалгалтуудын нэгдсэн дүн мэдээг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн, үнэлэлт дүгнэлт өгч түүний мөрөөр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар үүрэг даалгавар, зөвлөмж чиглэл гаргаж ажиллалаа.

Нээлттэй утас 22122-ыг ажиллуулж ард иргэд аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн санал хүсэлт гомдлыг шуурхай барагдуулах, улсын байцаагч нарыг хамтарсан шалгалт хийж хамтарсан дүгнэлт гаргуулах хяналт шалгалтын давхардлыг арилгах зорилгоор “Багаар ажиллах багын зохион байгуулалтанд оруулах, ажлын давхардлыг арилгах зорилгоор ажлын байрны тодорхойлолтыг шинэчилэх, объектын жагсаалт гаргах, улсын байцаагч нарын ажлыг бодитой үнэлж дүгнэх, жил бүр байцаагч нарыг дотооддоо сургах, мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх сургалтанд хамруулах, туршлага судлуулах зэрэг ажлуудыг тогтмол зохион байгуулж хэвшиж байна.

Санхүүгийн хяналт шалгалтаар 209395.2 мянган төгрөгийн акт тогтоосноос 190003.5 мянган төгрөг буюу 90.6 хувийг барагдуулж, улсын байцаагчид зөрчил гаргасан байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан иргэнд нийт 6924.0 мянган төгрөгийн торгууль шийтгэвэр ногдуулж 6839.0 мянган төгрөг буюу 99.1 хувь барагдуулсаны зэрэгцээ шалгалтын явцад

стандартын шаардлага хангаагүй 3610.7 мянган төгрөгний хүнсний бүтээгдэхүүнийг устгуулсан байна.

Аймгийн Стандартчилал хэмжил зүйн төвийн лаборатори нь аймаг орон нутгийн хэмжээнд импортын болон дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнүүдэд хими, бактерлоги, хор судлал, хорио цээрийн шинжилгээнүүдийг хийж холбогдох дүгнэлтүүдийг гаргаж ажиллалаа.

2009 онд МХГ-аас хийсэн хяналт шалгалтанд давхардсан тоогоор нийт 2436 байгууллага, аж ахуйн нэгж, 1642 салбар нэгж, 2731 цэг байгууламж, 7501 иргэн хамрагдсан ба шалгалтын 1051 буюу 50 гаруй хувийг нь хамтарсан байдлаар хийлээ.

Хяналт шалгалтаар нийт 3584 зөрчлийг илрүүлж, 2556 зөрчлийг буюу 71.3 %-ийг арилгуулаад байна. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулхаар давхардсан тоогоор 1561 заалт бүхий 361 албан шаардлага өгсөн ба хэрэгжилт 79.4 хувьтай байна.

Энэ хугацаанд 763 заалт бүхий 347 дүгнэлт гаргасан ба 627 заалттай 347 акт гаргаснаас хэрэгжилт 97.5 хувьтай байна. 4 байгууллага, 2 салбар нэгж, 44 цэг байгууламжийн үйл ажиллагааг бүрмөсөн зогсоож, 41 байгууллага, аж ахуйн нэгж, 18 салбар нэгж, 18 цэг байгууламжийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох арга хэмжээ авч, зөрчил дутагдлыг арилгуулан 20 байгууллага, аж ахуйн нэгж, 12 салбар нэгж, 3 цэг байгууламжийн үйл ажиллагааг сэргээн ажиллуулсан.

Аймгийн МХГазарт 2009 онд байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл гомдол нийт 218 ирсэнээс хуулийн хугацаанд шийдвэрлэсэн 198 буюу 89.4 %, шийдвэрлэх хугацаа болоогүй 14 буюу 6.5 % байна. Шийдвэрлэх хугацаа хэтэрсэн 6 буюу 2.8 хувьтай байна.

Тус байгууллага энэ онд төлөвлөгөөт болон удирдамжтай хэд хэдэн томоохон шалгалтыг хамтран болон дангаар зохион байгууллаа. Тухайлбал:

- Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас тус аймагт хийгдсэн Нэгдсэн шалгалт
- Улаангом суманд Нэгдсэн шалгалт
- Аймгийн түлш эрчим хүчний байгууллагууд Дулааны станц, Улаангом ЦТШС ХХК, Чандмань –Увс ХХК-уудад хамтарсан шалгалт
- Эрдэм-Оргил, Шинэ-Ирээдүй, Чандмань эрдэм ахлах сургуулиуд, Бөхмөрөн, Түргэн, Сагил, Музей, Номын сан, Хүнс хөдөө аж ахуйн газар, Биеийн тамир спортын хороо, Төрийн сан, Сангууд, Газар тариалан эрдэм шинжилгээний станц, Хүүхдийн төлөө төв, Зүүнговь сумын төрийн сан, Боловсрол соёлын газарт санхүүгийн шалгалт
- Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгж иргэд, төмс хүнсний ногоо худалдан борлуулдаг аж ахуйн нэгж иргэд, сүү, сүүн бүтээгдэхүүн, хуванцар саванд меламина илрүүлэх шалгалт
- Согтууруулах ундаа, түүгээр үйлчилдэг худалдан борлуулдаг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийг аттестатчилах шалгалт
- Барилгын угсралт, барилгын материалын үйлдвэрүүдэд хийгдсэн шалгалт
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаж байгаа ААН-үүдийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт
- Орон нутгийн “Авто замын сан”-гийн төвлөрүүлэлт, зарцуулалт, болон авто зам, замын ашиглалт, угсралт, засвар арчлалт, шинэчлэлтийн байдалд хийсэн хяналт шалгалт
- Аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн ААНБ-д хийсэн хяналт шалгалт гэх мэт.

Нийтлэг илэрч байгаа зөрчлүүд

Санхүүгийн чиглэлээр

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу ААНБ нягтлан бодох бүртгэлээ аккурел сууриар хөтөлнө, хэрэв мөнгөн сууриар хөтөлдөг бол жилийн эцсийн

санхүүгийн тайлангаа аккурел суурьт хөрвүүлэн гаргана гэсэн заалтыг зөрчиж ажлын төлбөр, хураамжийг орж ирсэн эсэхээс үл хамаарч орлогоор бүртгэлд харуулах ёстой байтал зөвхөн мөнгөн хөрөнгө нь орж ирсэн гүйлгээг бүртгэх, мөнгө төлөгдөөгүй орлогыг авлагад тусгадаггүй

2.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг нийтээр зөрчиж байна.

3.Хандивын хөрөнгийг данс бүртгэлд тусгадаггүй, үр ашиггүй зарцуулдаг

4.Дутуу болон илүү олгосон цалин хөлс, ашиглаж дутагдуулсан хөрөнгө, үндсэн баримтгүйгээр данс бүртгэлд тусгалгүйгээр зарцуулсан, урамшуулал, түлш, хоолны хөнгөлөлтөөс НДШ тооцдоггүй зэрэг нийтлэг зөрчлүүд илэрч байна.

6.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар анхаарч ажиллахгүй, тухайлбал хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэлгүй ажиллуулж байгаа зөрчил хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлээр нийтлэг илэрч байна.

7.Хөдөлмөрийн хяналтын чиглэлээр цалин хөлстэй холбоотой зөрчлүүд дийлэнхи олонхийг эзлэж байгаа бөгөөд үүний дотроос нэмэгдэл хөлс, нэмэгдлийг хууль дүрэмд заасны дагуу олгохгүй байгаа зөрчил, зарим нэг ААН-үүдэд, үйлдвэр аж ахуйн газруудад машин механизм тоног төхөөрөмж ажиллуулах техникийн паспортгүй тоног төхөөрөмжийг ашиглах зөрчил нийтлэг байна.

Боловсрол эрүүл мэнд, хүнсний үйлдвэрлэл, худалдаа, хөдөө аж ахуйн чиглэлээр

1.Хог хаягдал зайлуулах нэгдсэн систем төгс бүрдээгүйгээс хур хог оршин суугчдын бүсэд үүсч орчны бохирдолт төдийлөн буурахгүй байна.

2.Хүнсний худалдаа, нийтийн хоолны газрууд үйл ажиллагаандаа байнгын мөрдөж ажиллах дүрэм журмаа хэвшүүлэхгүй, шалгалт яваад өнгөрсний дараа үйл ажиллагаагаа сулруулдаг зөрчил давтагдаж байна.

3.Зөвшөөрөлгүй цэгт хүнсний бүтээгдэхүүн худалдаалдаг зөрчил арилахгүй байна

4.Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулахгүйгээр зарж борлуулдаг явдал хэвээр байна.

5.Айл өрх, иргэд хашаандаа гар аргаар мал нядлах, худаг гаргах, мал амьтны гаралтай түүхий эд, арьс шир, ноос ноолуурыг ил задгай газар гудамж талбайд худалдан авах, борлуулах үйл ажиллагаа зогсохгүй байна.

Дэд бүтэц байгаль орчин геологи, үүл уурхайн чиглэлээр

1.Аймгийн хэмжээнд үйлдвэрлэл эрхэлж буй ААНБ-ууд тоног төхөөрөмж, шугам сүлжээний техник ашиглалтын паспорт хөтлөлт хангалтгүй хийгддэг.

2.Нийтийн зориулалттай орон сууцанд оршин суугч, иргэд, өөрсдийн дураар барилгын хийц эдэлхүүнийг өөрчилж, даацын ханыг эвдэлж нураах зөрчил буурахгүй байна.

3.Аймгийн хэмжээнд ашиглагдаж буй хуучин барилга байгууламжийг паспортжуулах ажил хангалтгүй явагдаж байна.

4. Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу шинээр байгуулах болон, одоо ажиллаж байгаа үйлдвэр, үйлчилгээ барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх болон нөөц хэлбэрээр байгалийн нөөц баялаг ашиглах төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэх гэсэн хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Тайлант хугацаанд Ерөнхий менежерт нийлүүлэх бүтээгдэхүүнийг тоо чанар, шалгуур үзүүлэлтийн дагуу жилийн эцэст 93.5 хувиар биелүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулахад орон нутгийн төр захиргааны байгууллагын удирдлагуудтай холбогдож ажиллах, хяналт шалгалт бүрийн эцсийн үр дүнг дээшлүүлэхэд зөвлөмж чиглэл өгөх, биелэлтийг хангуулах замаар улсын байцаагчдын хариуцлага сахилгыг дээшлүүлж, хяналт шалгалтыг зөрчил тууштай арилахгүй байгаа салбарт түлхүү хийх болсоноор геологи уул

уурхай, байгаль орчин, БСШУ, эм био бэлдмэл, хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, мал эмнэлэг, үржил, авто зам, газар тариалангийн салбарын хяналтын үр нөлөө дээшилж байна.

Хүнсний үйлдвэрлэл худалдаа, санхүү, эрчим хүч, барилга, авто тээврийн болон бусад чиглэлийн хяналтын үр дүнд ахиц гарч байна.

Харин газрын харилцаа, хүнсний эрүүл ахуй, нийгмийн хамгааллын чиглэлийн хяналтын үр дүнг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

Ерөнхий дүнгээр тус аймагт хууль тогтоомжийн хэрэгжилт дундач түвшинд байна гэсэн дүгнэлтийг хийж байна.

Шадар сайдын 12 ангийн 384 бүтээгдэхүүний дундач биелэлт 92 хувьтай байна.

3.1.4.Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн Яам

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Увс аймгийн Засаг даргын хооронд 6 ангийн нийгмийн хүрээнд хүний хөгжлийг хангах тэгш орчин бүрдүүлэх, нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх чиглэлийн 41 нэр төрлийн бүтээгдэхүүн худалдан авахаар харилцан тохиролцож энэхүү гэрээ байгуулсныг үндэслэн гэрээний биелэлтийг гаргаж хүргүүлэв.

Гэрээгээр тогтоосон тооноос сайн дурын даатгалд малчид албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдээс даатгуулагчид, шинээр нэрийн данс нээсэн хүний тоо, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжинд хамрагдсан өрх, иргэдийн тоо, нөхцөлт мөнгөн тэтгэмжинд хамрагдсан өрх, хүүхдийн мөнгөн тэтгэмжинд хамрагдсан хүүхэд, залуу гэр бүлд олгох мөнгөн тэтгэмжинд хамрагдсан гэр бүлийн тоо бага байлаа.

Хүн амын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор зохион байгуулж, Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал үндэсний хөтөлбөр, Жендэрийн тэгш байдлыг хангах, Өсвөр үе залуучуудын хөгжлийг дэмжих, Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөр болон Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг холбогдох газруудад тайлагнаж ,ядуу, нэн ядуу 384 өрхийг сонгон авч өрхийн хөгжлийн төлөвлөгөө хамтран боловсруулах, жендэрийн тэгш байдлын асуудлаар сумын ажилтнуудад сургалт хийх ажлыг зохион байгууллаа.

Аймгийн татварын албанд бүртгэлтэй ажил олгогчдын тооллого явуулж, нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогчдыг Татвар, МХГ, барилга хот байгуулалтын албатай хамтран харилцан мэдээлэл солилцож, ажил олгогч даатгуулагчдын хамрах хүрээг нэмэгдүүлэх, НДШ-ийн өр авлагыг бууруулах, сангийн орлого нэмэгдүүлэх ажлуудыг тодорхой үе шаттай төлөвлөн зохион байгуулж ажилласны үр дүнд шинээр 42 ажил олгогч , түүнд хамрах 71 заавал даатгуулагч болон 602 сайн дурын даатгуулагчийг нийгмийн даатгалд, 3965 даатгуулагчийг эрүүл мэндийн даатгалд шинээр хамрууллаа.

Тэтгэвэр тогтоолгохоор материал бүрдүүлсэн болон тэтгэврийн өөрчлөлттэй холбогдсон өргөдөл, хүсэлт ирүүлсэн 808 иргэнд нэг бүрчлэн зөвлөгөө өгч ажилласан ба шинээр 667 иргэнд өндөр нас, хөгжлийн бэрхшээлтэй иргэний, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоож, шилжиж ирсэн, явсан 314 иргэний материалыг шалгаж, мэдээллийн баазад оруулан зогсоогдсон 417 тэтгэвэр авагчийн мэдээллийг бүртгэж, оршуулгын тэтгэмж олгосон байна.

Оны эхнээс нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх зорилгоор сум, аж ахуйн нэгж, байгууллага бүрт орлогын төлөвлөгөөг хуваарилан хяналт тавьж, шимтгэлийн тайлан, даатгуулагчийн шимтгэл төлөлтийн тооцооны хуудсыг стандарт маягтаар бүрэн нөхүүлж хугацаанд нь авах, өглөг авлагаа сар бүр баталгаажуулах, малчид хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хуулийн сурталчилгаа хийж ажилласны үр дүнд 350 ажил олгогчийн 9979 иргэнийг заавал даатгалд, 1572 иргэнийг сайн дурын даатгалд, 57579 иргэнийг эрүүл мэндийн даатгалд хамруулан, нийгмийн даатгалын санд 4.8 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого оруулж, торгууль, алданги, бусад орлогоор 16.1 сая төгрөгөөр сангийн хөрөнгийг нэмэгдүүллээ.

Шимтгэлийн өр авлага үүсгэхгүй байх талаар хуулийн хүрээнд олон талт ажил зохион байгуулсны үр дүнд 85.1 сая төгрөгийн хуримтлагдсан авлага барагдаж, оны эхэнд байсан 173.9 сая төгрөгийн шимтгэлийн авлага 88.8 сая болж, 48.9 хувиар буурсан бөгөөд шимтгэлийн орлогод авлагын эзлэх хувь оны эхэнд 4.4 хувь байсан бол эцэст 3.5 хувь болж 0.9 хувиар буурлаа.

Шимтгэлийн авлага бууруулах аяныг зохион байгуулж, авлага бүхий байгууллагуудын удирдлагад албан шаардлага, хугацаат мэдэгдэл өгөх, төлбөр барагдуулах гэрээ, протокол байгуулах, банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоох, шүүхэд нэхэмжилж шийдвэр гаргуулах болон бусад байгууллагуудтай хамтран ажилласны үр дүнд оны эхэнд байсан 312.7 сая төгрөгийн авлагаас 199.8 сая төгрөгийг барагдууллаа.

Тэтгэвэр, тэтгэмж, хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсэн амаржсаны, оршуулгын тэтгэмж, ажилгүйдлийн даатгалын сан, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр бүгд 57835 даатгуулагчид 10541.7 сая төгрөгийг хугацаанд нь олгосон байна.

Шинээр ажлын байр бий болгох зорилгоор оны эхэнд сумын Засаг дарга нартай хийх бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд сумдын хүн ам, ажилгүй иргэдийн тоо, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх боломж зэргийг үндэслэн шинээр бий болгох ажлын байрны төлөвлөгөө өгч, ажилгүй иргэдийг мэргэжил олгох түр сургалтанд хамруулах, нийтийг хамарсан ажлын төсөл хэрэгжүүлэх, иргэдийг жижиг зээлийн үйлчилгээнд хамруулж шинэ ажлын байртай болгох арга хэмжээг хамтран авч хэрэгжүүлсний үр дүнд 1409 хүнийг ажилд зуучилж байнгын ажлын байраар хангалаа. Мэргэжил олгох сургалтанд ажилгүй, ядуу, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг жигд хамруулан сургахаас гадна ажил олгогч байгууллагын захиалгаар албан бус салбарт ажиллагсдыг сургах чиглэл баримтлан 2009 оны сургалтын хэрэгцээг төлөвлөн хэрэгжүүлж ажилласны үр дүнд жил эцсийн байдлаар 22 төрлийн мэргэжлээр 605 хүнийг сургаж мэргэжлийн үнэмлэх, чадамжийн гэрчилгээ олголоо. Аж ахуй эрхлэх, төсөл хөтөлбөр боловсруулах сургалтыг 9 удаа зохион байгуулж 200, малчны сургалтыг 4 удаа зохион байгуулж 100 хүнийг тус тус хамруулж сургалтын зардалд 68910,4 мянган төгрөг зарцууллаа. Дээрх сургалтанд хамрагсдын 58 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байсны дээр сургалтанд хамрагдагсдын 70 хувь нь ажлын байртай боллоо.

Аймаг сумын хэмжээнд нийтийг хамарсан ажлын 54 төсөл шалгаруулан зохион байгуулж 1496 ажилгүй иргэдэд түр ажлын байр бий болгосноос гадна эмзэг бүлгийн 1110 иргэд уг ажилд хамрагдаж, тэдэнд 101.9 сая төгрөгийн цалин хөлс олголоо.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын нэг хэсэг нь хувиараа буюу хоршоо нөхөрлөлийн хэлбэрээр хөдөлмөр эрхлэх иргэнийг дэмжих жижиг зээлийн үйлчилгээ бөгөөд Хас, Монгол шуудан, ХАА-н банкаар дамжуулан иргэн, аж ахуйн нэгжид 496 ажлын байранд 425000,0 мянган төгрөгийн зээл олгож хяналт тавьж ажиллаа. 49 хүнд зээлийн хүүгийн нөхөн төлбөрт 6977,5 мянган төгрөг олголоо.

Хөдөлмөр эрхлээгүй хүн ам, ажилгүйчүүдтэй ажиллахын зэрэгцээ ажил олгогч нарыг урамшуулан дэмжих, ажилгүйдлээс урьдчилан сэргийлэх мэргэжлийн зөвлөгөө өгөх зэрэг арга хэмжээний үр дүнд 1496 хүн шинээр бүртгэгдэж 3202 хүнд мэргэжлийн зөвлөгөө өгч, 15 байгууллагын 84 хүний ажлын байрны нөхөн төлбөрт 56897,4 мянган төгрөг зарцууллаа.

Аймаг сумын хэмжээнд 25 буюу түүнээс дээш ажиллагсадтай 109 аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийг гарган шалгалт хийж ХБИ-ийг ажииллуулаагүй байгууллага аж ахуйн нэгжид зөвлөгөө өгч төлбөр төлүүлэх талаар анхааруулга мэдэгдэл өглөө. 2009 онд 4 байгууллагаас 1555200 төгрөгийн төлбөрийг тусгай дансанд хуримтлууллаа.

Төрөл бүрийн сургалтанд 58 ХБИ-ийг хамруулж, 55 хүнийг ажлын байртай болгох зорилгоор 22967,0 мянган төгрөгийн буцалтгүй тусламжийг төслийн хэлбэрээр санхүүжүүллээ. Бичил зээлийн үйлчилгээнд 12 ХБИ-ийг хамруулж 12.0 сая төгрөгийн зээл тусламж олголоо.

Монгол Улсын Засгийн газраас баталсан Нийгмийн эмзэг бүлэгт хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөрт 846 иргэн хамрагдаж, сар бүр 14000 төгрөгний хүнс тэжээлийн дэмжлэг авч эхэллээ.

Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны байранд ХБИ-ийн үндэсний хөтөлбөрийг сурталчлан таниулах зорилгоор байнгын ажиллагаатай мэдээллийн самбар ажиллуулж байна. Хүүхдийн тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөртэй тэмцэх дэлхий нийтийн өдөрт зориулсан хөдөлмөрийн яармагийн үеэр ХБИ-ийн хийсэн бүтээлээр үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, орон нутгийн мэдээллийн хэрэгслээр 2 удаа мэдээлэл сурталчилгаа хийлээ. ХБИ-ийн суурь судалгааг сум тус бүрээр гаргаж, тэднийг ажиллуулж болох байгууллагуудын судалгааг гарган хүргүүлж, ажиллуулах талаар үүрэг чиглэл өглөө.

Аймгийн ХБИ-ийн анхдугаар чуулга уулзалтыг аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулж тодорхой асуудлуудыг хэлэлцэж, зөвлөмж гаргалаа. ХБИ-дэд ээлтэй дэд бүтэц бий болгох талаар аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллаж энэ онд 5 байгууллагад дэд бүтэц бий болголоо. ХБИ-ийн сургалт үйлдвэрлэлийн төвийн барилгыг аймгийн төсвөөр барьж барилгын ажлын 80 гаруй хувийг гүйцэтгээд байна.

Мерсу кор ОУ-ын байгууллагатай хамтран “Колумбия хөгжлитийн бэрхшээлтэй иргэдийн тэгш боломжийн төлөө” 3 сарын аяныг зохион байгуулж дүгнэлээ.

Увс аймагт нисэх буудлын барилгын ажилд 25 хятад иргэн ажиллаж байсан ба тэднийг бүртгэлд хамруулж тухайн үед нь хяналт тавьж ажиллалаа.

Сумдад хяналт үнэлгээ хийж, иргэдтэй уулзаж хууль тогтоомжийг сурталчлах, тэдний сонирхсон асуултанд хариулах, өргөдөл гомдлыг газар дээр нь шийдвэрлэж хариу өгөх, сумдын нийгмийн ажилтны ажлыг шалгаж арга зүйн зөвлөгөө өгөх, өрхийн амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдтэй уулзаж мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөлийн ажлыг шалгаж үнэлэлт дүгнэлт өгөх, ажлын үр дүнг тооцох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Давхардсан тоогоор 17984 хүнд сурталчилгаа хийж, ажлын тайланг “Увсын өнгө” сонинд нийтлүүлж, аймгийн нийт иргэд, үйлчлүүлэгчдэд сурталчиллаа.

Аймгийн МВС телевизээр нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой иргэдийн асуулт, мэдээлэлд хариулт өгөх, мэдээлэл хийх ажлыг 4-6 удаа, нээлттэй хаалганы өдөр, хөдөлмөрийн яармагийн үйл ажиллагааны талаар 2 телевизээр 8 удаа сурталчилгаа хийж, нээлттэй микрофон ажиллуулж иргэд үйлчлүүлэгчдийн санаа бодлыг сонслоо.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 1725 хүнд 843.8 сая төгрөг, нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 2121 хүнд 421.8 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж хөнгөлөлт үйлчилгээнд 1630 хүнд 144.5 сая төгрөг, ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт үйлчилгээнд 4830 хүнд 185.1 сая төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмжинд 35682 хүүхдэд 1219.1 сая төгрөг, шинээр төрсөн хүүхдэд нэг удаа олгох мөнгөн тусламжид 2460 хүүхдэд 246.0 сая төгрөг, шинэ гэр бүлд олгох мөнгөн тусламжид 632 гэр бүлд 316.0 сая төгрөг, жирэмсэн болон хөхүүл нярай хүүхэдтэй эхэд олгох мөнгөн тэтгэмжид 2592 хүнд 504.8 сая төгрөг, Алдарт эх одонтой эхчүүдэд олгох тусламжид 5440 эхэд 353.1 сая төгрөг, 0-18 насны хүүхэд бүрт Монгол улсын хөгжлийн сангаас олгох 100.0 мянган төгрөгийн тэтгэмжид 35453 хүүхдэд 3141.0 сая төгрөг тус тус олголоо.

Төсөвлөгдсөн хөрөнгө мөнгө байхгүй хэдий ч дотоод нөөц боломжоо ашиглан 6 сараас эхлэн Хархираагийн амралтанд 7 хоногийн ээлжээр 12 ортой ахмадын “Алтан үе” сувилал ажиллуулж, 252 ахмад настанг амрааж сувиллаа.

Өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй, нэн ядуу амьдралтай, ганц бие ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг байнгын асрамжийн үйлчилгээнд хамруулж, тэдний нийгмийн асуудал бусад үйлчилгээнд 150.7 сая төгрөг зарцуулж, нийгэм хамт олонд түшиглэсэн, гэрийн нөхцөлд ойртуулах асрамжийн үйлчилгээний зарим хэлбэрийг нэвтрүүлж ажиллаад байна. Асруулагчдыг зуны 3 сарын хугацаанд Хархираагийн амралтанд гэрийн нөхцөлд асрамжлах үйлчилгээг үзүүлж, асруулагчдын байранд урсгал засвар хийлээ. Тус аймагт Асрамжийн байгууллага үүсч хөгжсөний 70 жилийн ойг аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлээ.

2009 онд аймгийн хэмжээнд зорилтот бүлгийн 59 өрхийг ядуурлаас гаргах, амьжиргааны эх үүсвэртэй болоход нь зориулж зохион байгуулалттай хөдөлмөр эрхлэх 32 бүлэг үүсгэн нийт 20 сая төгрөгийг уг зардлаас санхүүжүүлэн ажиллалаа.

ОНОТХУ-ний нэг хэлбэр болох нөхөн сэргээх үйлчилгээг аймгийн Ахмадын хороо ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж 2 сая төгрөгөөр санхүүжүүлэн Улаангом сумын 2000 гаруй ахмадад үйлчилгээ үзүүлж байна.

Байнгын асаргаа шаардлагатай эмзэг бүлгийн иргэдийг сэргээн засах гэрийн үйлчилгээг “Энэрэл” ТББ- аар 14.4 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүлж, хяналт тавин ажиллаж байна.

19 сумын амьжиргаа дэмжих зөвлөлийн 133 гишүүдэд сургалт зохион байгуулж гарын авлага, материал, арга зүйн удирдлагаар хангаж ажиллаж, хийсэн ажлын үр дүнг харгалзан зөвлөлийн гишүүн 133 хүнд 19,7 сая төгрөгийн урамжуулал олголоо.

Ахмадын хороогоор дамжуулан “Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа. Ахмадын сан байгуулах ажил өнгөрсөн жилүүдэд эхлэл төдий байсан бол 2009 онд 50 гаруй аж ахуйн нэгж байгууллага ахмадын сан байгуулж, зарим байгууллага нь тусгай данс нээн ажиллах боллоо.

Мерси Кор олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр “Идэвхтэй хөдөлгөөн-эрүүл мэнд” 8.5 сая төгрөгийн өртөгтэй төсөл хэрэгжүүлж, 20-оод нэр төрлийн спортын хэрэглэгдхүүнтэй чийрэгжүүлэлтийн төв, танхимтай болсноор ахмадууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаа арилгаж эрүүлжих нөхцөл бүрдүүлсэн. Өдөрт 15-20 ахмад настан тус төвөөр тогтмол үйлчлүүлдэг болсон.

Төсөл хэрэгжих хугацаанд 3000 гаруй ахмадыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулж, эрүүл ахуйн талаар 500 гаруй ахмадуудад хичээл зааж, 6000 гаруй ахмадуудад гарын авлага товхимол тараалаа.

Тогтвортой амьжиргаа төсөлд хандаж 13 сумын ахмадын хороонд 17.0 сая төгрөгийн төсөл хэрэгжүүлж тоног төхөөрөмжөөр хангаснаар ахмадууд цуглаж ярилцах, үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл бүрдүүлээ.

Сайдтай байгуулсан гэрээний 5 ангийн 41 бүтээгдэхүүнийг дундчаар 89 хувиар биелүүллээ.

3.1.5. Эрүүл мэндийн Яам

Увс аймгийн Засаг даргаас эрүүл мэндийн сайдын (эрүүл мэндийн Төсвийн Ерөнхийлөн захирагч) худалдан авах бүтээгдэхүүнийг 6 ангийн хүрээнд хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар үр ашгийг дээшлүүлэх чиглэлийн үндсэн ангийн 9, тусгай захиалгат 6 бүтээгдэхүүн худалдан авахаар талууд харилцан тохиролцож гэрээ байгуулав.

2009 оны байдлаар стационарт 18910 өвчтөн эмчлэгдэж 142418 ор хоног ашиглаж дундаж ор хоног 7.4 болж хүрэх түвшингээс 0.2 –иар буурч орны эргэлт сайжирсан үзүүлэлттэй байна.

Өнгөрсөн мөн оны түвшинтэй харьцуулахад эхийн эндэгдэлгүй ажилласан боловч нялхсын эндэгдэл /амьд төрсөн 1000 хүүхдэд/ 8.5, 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /амьд төрсөн 1000 хүүхдэд/ 10.0 пунктаар тус тус нэмэгдсэн.

Тав хүртэлх насны хүүхдийн гэрийн эндэгдлийн эзлэх хувь, жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийн хэрэглээний хувь харьцангуй доогуур үзүүлэлттэй байна.

Завхан, Давст сумын эмнэлэг, Спорт цогцолборыг шинээр барьж ашиглалтанд оруулж, Тэс, Хяргас сумын эмнэлгийн барилгад их засвар хийгдлээ.

Эрүүл мэндийн газрын газрын дарга аймгийн Засаг даргатай /Төсвийн Ерөнхийлөн Захирагчид/ үндсэн 9, тусгай захиалгат 6 бүтээгдэхүүнийг 370932.8 мянган төгрөгний өртөгөөр нийлүүлээ.

ЭМГ-ын удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгон боловсон хүчин, материаллаг бааз, эдийн засаг, санхүүгийн албыг бэхжүүлж чадавхийг нь дээшлүүлэхийн тулд ЭМС-ын 2009 оны 02 дугаар тушаалын биелэлтийг 7 багцаар үйл ажиллагааны төлөвлөгөө бичиж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эрүүл мэндийн сайдын 2009 оны 74 тоот тушаалыг үндэслэн аймгийн Засаг даргын 111 тоот захирамжаар эрүүл мэндийн газрын дүрэм, бүтэц зохион байгуулалтыг 33 орон тоогоор батлагдаж нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээг аймгийн хэмжээнд удирдлага, зохион байгуулалт, арга зүйгээр ханган ажиллаж байна.

ЭМГ-ын агентлагын харъяалалд 73 нэгж байгууллагад их эмч эмнэлгийн дээд мэргэжилтэн 149, бага эмч 116, сувилагч тусгай мэргэжилтэн 354 нийт 951 орон тоотойгоор үйлчлэх хүрээний 79 багийн 19903 өрхийн 79.4 мянган хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй үзүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Тус аймагт 2009 онд нийт 907 халдварт өвчин бүртгэгдэж өмнөх оноос 5 тохиолдлоор буурч салхин цэцэг, гахайн хавдар, сүрьеэ, хамуу, хүйтэн өвчнүүд нэмэгдэж халдварт шар 66 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.

БЗДХ нийт-135 илэрч (тэмбүү 28, заг хүйтэн 52, трихомониаз 26, мөөгөнцөр 20, үү ургацаг 6) хяналтанд орж хавьтлыг судлан илрүүлж эмчилгээнд хамрууллаа.

ХДХВ/ДОХ/БЗДХ-н талаархи ойлголт түүнээс урьдчилан сэргийлэх, халдвар дамжих замыг таслан зогсооход хувь хүний үүрэг, бэлгэвчийн хэрэглээ, бэлгэвч хэрэглэх арга” сэдэвт сургалтанд сайн дурын идэвхтэн, өсвөр үеийн зөвлөгч, сумдын эмэгтэйчүүдийн зөвлөлийн гишүүн, үе тэнгийн сургагч / 7-11 анги/ ЕБС-ийн ахлах ангийн дарга нийт 130 хүнийг сургалтанд хамрууллаа.

БЗДХ –ыг хам шинжээр нь оношлох, эмчлэх сургалтанд аймгийн төвийн болон сумдын эх баригч их, бага эмч, өрхийн эмч, сувилагч, лаборант багийн бага эмч нарыг Серологи шинжилгээ хийх арга барил эзэмших дадлагатай сургалтанд хамрууллаа.

Шинээр гарч буй халдварыг богино хугацаанд цомотгон өвчлөлийн тархалтыг бууруулах дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

Нийгмийн цаг үеийн байдалтай уялдуулан Ариун цэврийн хэвийн нөхцлийг хангах тухай, Н₁N₁ цар тахалтай тэмцэх шуурхай штаб ажиллуулах, халдварт ба халдварт бус зарим өвчинтэй тэмцэх тухай, Нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх тухай, дахрлаажуулалтын 10 хоногийг зохион байгуулж шинэ гарсан зарим вакциныг нэвтрүүлэх тухай аймгийн Засаг даргын.....дугаар захирамжууд гарч аймгийн Засаг даргын тамгын газар, Улаангом сумын

Засаг даргын тамгын газар, Онцгой байдлын комисс, аймгийн нэгдсэн эмнэлэг, боловсрол соёлын газар, мэргэжлийн хяналтын газар, сумдын ЗДТГ, багийн дарга нартай хамтран аймгийн хэмжээнд сургалт, сурталчилгаа, болзолт аян, чуулга уулзалталуудыг зорилтот бүлгүүдийг хамруулан үйл ажиллагаа явуулсан байна. Бүх сумдын бохир усны цооног, бие засах газарт ариутгал халдваргүйтлийг 3- 4 саруудад авгалдай устгах ажлыг ЭМГ –ийн баг сумдын Засаг дарга нартай хамтран явуулсан.

Аймгийн хэмжээнд Дархлаажуулалтыг товллоор зааврын дагуу хийж хамрагдалт 99.8 хувьтай байна.

Тахлын голомтод хийгдэх эпизоотологийн шинжилгээний календарчилсан төлөвлөгөөний дагуу Тариалан, Түргэн, Давст, Сагил сумын секторыг хамарсан 63000 га-д тарваган тахлын тандалт шинжилгээг хийж лабораторийн өсгөвөр ба эерэг хариутай материал илрээгүй голомт тайван байна гэсэн дүгнэлтийг БГХӨСТ ийн нян судлаач эмч нар ирүүлсэн байна.

Халдварт бус өвчин: Аймгийн хэмжээнд халдварт бус өвчлөл 28238 тохиолдол бүртгэгдсэнээс 73.3 хувийг шинэ бүртгэгдсэн өвчлөл, 26.7 хувийг хуучин ба архаг өвчлөл, 11.4 хувийг 5 хүртэлх насны хүүхдийн АЗЦХӨ эзэлж байна.

НҮЭМ-ийн үндэсний Здахь хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн ажилласнаар 2009 онд эхийн эндэгдэл гаргалгүй ажиллаа. Олон улсын эх баригчдын өдрийн хүрээнд төв хөдөөгийн эх баригчдын ур чадвар, мэдлэг сорих шалгалт авч “НҮЭМ-ийн үндэсний хөтөлбөрийн шалгуурын биелэлтийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” сэдвээр 7 эх баригч илтгэл хэлэлцүүлсэн.

Нүүдлийн тусламж төслөөр хүүхэд, эмэгтэйчүүд, дотор, зүрх судас, ЭХО-ийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг давхардсан тоогоор 500 гаруй хүнд үзүүлж, НҮЭМ/ГБТ/БЗД, амьдрах ухааны талаар мэдээлэл сурталчилгаа хийж, 20 гаруй сурталчилгааны материал тараалаа.

Ирээдүйн босго төвөөр 1614 өсвөр үе залуучуудад тусламж үйлчилгээ үзүүлж, үүнээс 414 хүнд шинжилгээ хийж БЗДХ-тай 42 тохиолдлыг илрүүлэн эмчилгээ хийж байна.

Ганцаарчилсан зөвлөгөөг 559, утсаар 471 өсвөр үе залуучуудад зөвлөгөө өгсөн. Ирээдүйн босго, СДЗШТөв хамт байрладаг нь тусламжийг цогцоор үзүүлэх нууцлалыг хадгалах, зөвлөгөөний үр дүнг тооцох боломжийг олгож байна.

2009 онд нийт 2253 эх төрж 2386 хүүхэд эсэн мэнд эх барьж эцэг эхэд нь хүлээлгэн өгсөн байна. Хүүхдийн эндэгдэл улсын дундаж түвшингээс өндөр байгааг анхааран оны эхнээс Эх, хүүхдийн эрүүл мэндэд төр, төрийн бус байгууллага иргэдийн оролцоо сэдэвт сургалтаас гарсан уриалгыг сайшаан Засаг даргын албан тоотыг хавсарган бүх сумдад хүргүүллээ.

Хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаа.

1. Эх хүүхдийн өвчлөл эндэгдлийг тууштай бууруулж эмч эмнэлгийн ажилтны мэдлэг ур чадварыг тасралтгүй дээшлүүлж ёс зүй, хариуцлагыг өндөржүүлэх хөтөлбөрийн хүрээнд суманд сүүлийн 5 жилд эндсэн хүүхдийн эндэгдлийн шалтгаанд 22 эмчээр судалгаа хийлгэж илтгэл тавиулан эндэгдлийг бууруулах зөвлөмжийг нэгжид хүргүүлсэн.

Уг зөвлөмжинд нярайн эндэгдлийн шалтгаанд жирэмсний хүнд хөнгөн хордлого 30.4 хувь, төрөх хүчний анхдагч болон хоёрдогч сулрал 19.4 хувь, ихэсийн дутмагшил 12 хувь, ураг орчмын ус эрт гарах 8.5 хувь, өгзөг төрүүлэлт /ургийн толгойн саатал/- 4.9 хувь, хугацаанаас өмнөх төрөлт 3.7 хувь, давтан кесаров 3.7 хувь, ихэс ховхрох 3.7 хувь, экламси 2.4 хувь, 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэлд нярайн эндэгдэлд золгүй тохиолдол, амьсгалын замын халдвар түүний хүндрэл,, гэртээ онош тодорхойгүй, суулгалт өвчнөөр эндсэнээс гадна нийт хүүхдийн 46.1 хувь нь суурь эмгэгтэй байсан нь анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа сум, өрхийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй, эцэг эхийн асаргаа сувилгаа хүүхдэдээ тавих анхаарал дутмаг байгаатай холбоотой гэсэн дүгнэлтийг тусган хүүхдийн эндэгдэл бууруулан ажиллах чиглэл, арга зүйг дурдаж үйл ажиллагаандаа хэргэжүүлэн ажиллахыг зөвлөсөн болно.

2. Хүүхдэд зонхилон тохиолдох зарим эмгэгийн оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, орчин үеийн хандлага” сургалтыг аймгийн Засаг Дарга , ЗДТГ-ын НХХ , ЭМГ, ЭНЭШТ-ийн сургалт хамтын ажиллагааны албатай хамтын ажиллагаа санхүүгийн дэмжлэгтэйгээр явуулан хүүхдийн чиглэлээр ажиллаж байгаа их эмч нарт ажлын байрны сургалт явуулан 254 хүүхдийг үзэж тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

3. Аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын 7 хүүхдийн их эмчийг туршлага судлах ажлын байрны, хүүхдийн эмчийн баримжаа олгох, 4 сувилагчийг хүүхдийн дадлагатай ажлын байрны сургалтанд хамруулах

4. Амь тэнссэн байдалд хүүхдэд үзүүлэх яаралтай тусламж, Эрэмбэлэн ангилах яаралтай тусламж”-ийн 3-5 хоногийн 2 удаагийн сургалтыг 14 сумын их эмч, нэгдсэн эмнэлэг, өрх багийн эмч, хүүхдийн сувилагч нарт

Хүүхдийн өвчний цогц менежмент эмнэлзүйн сургалтыг 11 удаа өрх сумын их, бага эмч, багийн эмч нарын хүрээнд

5. Эцэг эхийн тусламж хайх мэдлэг олгох сургагч багш бэлтгэх сургалтыг эх баригч бага эмч, сувилагч бага эмч , НЭМА , эрүүл мэндийн туслагч, эцэг эхчүүдэд сургалт явуулж Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг сум, өрхийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, тасралтгүй байдлыг холбогдох эмч мэргэжилтэн нартай хамтран дүгнүүлж ажиллаж байна.

6. Жирэмслэлт, төрөх тойрны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор ЭНЭШТ-өөс сургагч багшийг урьж төрөх эмэгтэйчүүдийн эмч нарт ажлын байранд нь ЭХО-ийн дагалдан сургалт хийлээ.

ЭМС-ын 2008 оны 10 сарын 02-ны өдрийн 220 тоот тушаалын дагуу 2009 онд 6 сарын хугацаатай гэрээ байгуулан Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасаг, Бөхмөрөн, Тэс, Тариалан, Ховд сумдад УЭНЭШТ-ийн хүүхдийн дотрын клиникийн амьсгалын эрхтний эмгэг судлалын тасгийн их эмч О. Солонго ажиллуулан ажлын байрны давтан сургалтыг явуулж байсан нь эмч нарын тасралтгүй сургалтанд ач холбогдолоо өгсөн үйл ажиллагаа боллоо.

Анхан шатны маягтын хөтлөлтийг аймгийн нэгдсэн эмнэлэг, 18 сум өрхийн эмнэлэг, хувийн хэвшлийн 20 гаруй байгууллагуудад УМХЕГ- тай хамтран хяналт үнэлгээ хийж илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээ авч тодорхой үүрэг даалгавар өгч үйл ажиллагааны төлөвлөгөө гаргуулан ажиллаж, анхан шатны маягтыг хөтлөх, стандарт, гарын авлагыг байгууллагуудад хүргүүлээ.

Биеийн тамир спортын газартай хамтран төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж буй ажиллагсдыг бие бялдрын түвшин тогтоох сорил судалгаанд 48 байгууллагын жагсаалт гарган 594 хүнд бие бялдрын түвшин тогтоох сорил судалгаанд хамруулж А – 339 буюу 57.1 хувь, В – 129 буюу 21.7 хувь, С – 79 буюу 13.2 хувь, D – 21 буюу 3.5 хувь, F – 14 буюу 2.4 хувь гэсэн үнэлгээний дагуу хийх дасгал хөдөлгөөнийг зургаар гаргаж гарын авлага материал бэлтгэн ашиглаж эхлээд байна.

Сумын эмнэлгийн эмийн тендерийг 19 багц болгон зарласнаас 16 багцанд 6 эм ханган нийлүүлэх компани материалаа ирүүлж тендэрт оролцсоноос 3 багцын үнэ эрүүл мэндийн байгууллагын санал болгосон үнээс хэт өндөр байсан учир хасаж 13 багцанд шалгаруулалт хийж 463731098 төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гэрээг 6 байгууллагатай хийлээ.

Хүний нөөцийн судалгааг нэгж бүрээр тусгай асуумжийн дагуу бүртгэл хийж ЭМЯаманд хүргүүлэн сум, сум дундын эмнэлэгт 5-аас дээш жил ажилласан 8 эмч мэргэжилтнүүдэд 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний 9867.6 мянган төгрөгийн мөнгөн тусламжийг олголоо.

Сайдтай байгуулсан гэрээний 6 ангийн 15 бүтээгдэхүүнийг дундчаар 90 хувиар биелүүллээ.

3.1.6.Батлан хамгаалах Яам

Батлан хамгаалах асуудал эрхэлсэн сайдтай байгуулсан гэрээний хүрээнд батлан хамгаалах төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, түүний чанар үр нөлөөг дээшлүүлэх, батлан хамгаалах үйл ажиллагааг хэвийн явуулах боломж нөхцлийг хангах хэрэгжүүлэх зорилгоор 2009 онд сумдын тамгын газрын дарга нарт 2 хоногийн сургалт, семинар зохион байгуулж явуулсан.

БХЯ, ЗХЖШ-ыг сурталчилах төлөвлөгөө гарган БХЯ-ны чиг үүрэг, зорилго, ЗХЖШ-ын шинэчлэлийн бодлого, Батлан хамгаалах сургуулийг сурталчилах ажлыг орон нутагт зохион байгуулж ирлээ.

Цэрэг татлагын үеэр бүх сумдад цэргийн алба хаах журам дүйцүүлэх болон гэрээгээр алба хаах заавар зөвлөмж, бусад холбогдох хууль тогтоомжийг тайлбарлан таниулж, БХИС-ийн элсэлтийн шалгалтанд 103 хүүхэд бүртгэн авч шалгалтанд оруулан 9 хүүхдийг тэнцүүлэн материалыг бүрдүүлж БХИС-д элсүүлэн авлаа.

Орон нутагт байгаа хүчний болон хил хамгаалах 0245,0311-р ангитай харилцан ажиллах төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Сурталчилгааны ажлын хүрээнд

аймгийн хэмжээнд FM 107.5 радиогоор 5 удаа, орон нутгийн САМА, МВС телевизороор 8 удаагийн мэдээ мэдээллийн нэвтрүүлэг, Увсын амьдрал болон төвийн сонин хэвлэлд 2 удаа явууллаа Аймгийн төв сумдад бүгд 10 удаа лекц ярианы хэлбэрээр БХЯ хууль, Цэргийн штабын тухай мэдээллийг шуурхай зохион байгуулж байна.

Дайчилгааны үед ажиллах хүн хүч, машин техник бусад хэрэгслэлийн тооцоо судалгааг тодотгож сум, албад ААНБ бүрээр гаргаж бэлэн байдлыг хангуулах ажлыг орон нутагт зохион байгуулж байна. Мөн хүн техник хүлээн авах байр, цугларах байрны томилгоот бүрэлдэхүүнийг тодотгож шинэчлэх, нөхөн хангах, томилгоо хийх, шийдвэр гаргаж хүн тус бүрт ажлын үүрэг чиглэл зорилгыг тайлбарлаж дадлагажууллаа.

Орон нутгийн хамгаалалтын тогтолцооны үндсийг бүрдүүлэхэд чиглэсэн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж байна .

Аймгийн засаг даргын 13 тоот захирамжаар цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг 2009 оны 1-р сарын 04-наас 1-р сарын 16-ны хооронд сумуудад зохион байгуулж, сумдын дүн мэдээг 1-р сарын 17-19 нд шалган хүлээж авсан 2009 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлээр бэлтгэл офицер 110, цэргийн 1-р зэргийн бэлтгэл үүрэгтэн 11337, 2-р зэргийн үүрэгтэн 5705, Тусгай мэргэжлийн эмэгтэйчүүд 241 тус тус бүртгэгдсэн.

Аймгийн дүнгээр уналгын агт морьд 28675, ангийн буу 1311 ширхэгийг бүртгэж авлаа. Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн мэдээг нэгтгэж дүнг 2009 оны 1-р сарын 23-нд ЗХЖШтабт хүргүүлэв. Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг Өмнөговь, Бөхмөрөн, Улаангом зэрэг сумууд сайн зохион байгуулж явууллаа.

2009 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг татлагыг аймгийн Засаг даргын 13 тоот захирамжийг үндэслэн Цэргийн штабын даргын тушаал гарган бүх сумуудад хүргүүлж цэрэг татлага, халалтын ажлыг төлөвлөсөн хугацаанд нь зохион байгуулж явууллаа. 2009 онд цэрэг татлагаар нийт 1476 эрчүүд комисст орохоос 1032 эрчүүд комисст орж 208 хүн өвчнөөр, суралцах шалтгаанаар болон гачигдлаар 343 хүн чөлөөлөгдөж цэргийн албанд 370 эрчүүдийг шалгаруулан тэнцүүлж авлаа.

Цэргийн албанд тэнцсэн эрчүүдийг Улаанбаатар хот дахь цэргийн хүрээнд 20, ЗХ-ний 123-р ангид 50, Хил хамгаалахын 0277, 0130, 0245-р ангиудад нийт 300 нийт 370 эрчүүдийн цэргийн үүрэгтний үнэмлэх, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт шилжүүлэг хийснээр бичиг баримтуудыг бүрэн хүлээлгэн өглөө. 2009 оны 1, 2-р ээлжийн цэрэг татлага зохион байгуулж явуулсан хураангуй мэдээ, назологийн судалгаа нотломжийг ЗХЖШ-т заасан хугацаанд нь хүргүүлэв.

Аймгийн засаг даргын захирамжаар 2009 оны 1, 2-р ээлжийн цэрэг татлагаас зайлсхийсэн, зарлан дуудсан хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан цэргийн насны залуучуудын судалгааг сум сумдаар нь гаргаж Иргэний цэргийн үүрэгийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2-т зааснаар захиргааны хариуцлага тооцохыг сумдын засаг дарга нарт үүрэг болгов. Мөн өвчнөөр чөлөөлөгдсөн эрчүүдийн судалгааг гаргаж эрүүлжүүлэх ажлыг сумдад зохион байгуулах шийдвэр гаргаж хүргүүлэв. 2009 оны 1, 2-р ээлжинд халагдаж ирсэн дайчдыг нэг бүрчлэн хүлээн авч ЭМД, ЦҮҮ-ийг цэргийн мэргэжлийн дугаараар нь бүртгэж сумдын тамгын газрын дарга нарт хүлээлгэн өглөө.Цэрэг халалт, татлагын үеэр амаар болон бичгээр нийт 21 гаруй өргөдөл хүсэлт ард иргэдээс ирснийг тухай бүрд нь шийдвэрлэж хариу өгөв.

Гэрээт цэргийн албанд ЗХ-ний ангид 4, Хил хамгаалахын 0277-р ангид 4 цэргийн албан хаагчийг шалгаруулан тэнцүүлж материалыг бүрдүүлж хүлээлгэн өглөө. Мөн гэрээт цэрэг элсүүлэх ажлыг орон нутагт сурталчилан ажилласан.

Дүйцүүлэх алба хааж буй иргэдтэй Малчин, Наранбулаг сумуудад сургалт зохион байгуулсан. Сургалтын зэрэгцээ орон нутагт бүтээн байгуулалтын ажлууд хийгдсэн. Мөнгөн төлбөрөөр хаах иргэдийн судалгааг гарган ажиллаж 50 гаруй иргэнээс 10.1 сая төгрөгний төлбөр авч 50%-ийг төрийн санд шилжүүлж 50%-ийг орон нутагт төвлөрүүлээд байна.

Батлан хамгаалахын сайдын онц чухал –маш нууц 400 тоот, ЗХЖШ-ын даргын оч/мн 400/02 тоот удирдамжийн дагуу дайчилгааны бэлтгэл нөөц ба нөөцийн байрлалыг үнэн зөв тогтоож Зэвсэгт хүчний нэгтгэл ангиудыг бие бүрэлдэхүүн, техникээр тогтоосон хугацаанд дайчилгаагаар нөхөн хангах дарааллыг бодит үндэслэлтэй тодорхойлж сум, ААНБ-дад дайчилгааны бэлэн байдлын төлөвлөгөөний боловруулалт, чанар байдал, тодотголыг улирал бүр тодотгож сумуудаас заасан хугацаанд мэдээг хүлээн авч ажиллаа.

Аймгийн цэргийн штабын дайчилгааны төлөвлөгөөг жилд 2 удаа тодотгож ЗХЖШ –т хүргүүлсэн. Зэвсэгт хүчний анги нэгтгэлийг бие бүрэлдэхүүн техникээр хангах, Увс аймгийн дайчилгааны төлөвлөгөөгөөр оногдуулан данслагдсан командуудыг Зэвсэгт хүчний 123-р анги 325- ангийн АДЭХ 328-р салбартай тус бүр 2 удаа тодотгол хийлээ. Үүнд дайчилгааны даалгаврыг цэргийн бэлтгэл офицер, цэргийн үүрэгтэн, авто техникийн тодотголыг цэргийн мэргэжлийн дугаараар тулгаж тодотголоо.

2009 онд Дайчилгааны төлөвлөгөөний тодотгол, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрдүүлэлтийг Өмнөговь, Өлгий, Завхан, Тариалан, Наранбулаг, Ховд, Бөхмөрөн зэрэг сумуудад шалгаж ажлын үүрэг чиглэл өгсөн.

Аймгийн дайчилгааны төлөвлөгөөнд оногдуулан данслагдсан дайчилгааны даалгаврыг сумуудад хүргүүлж оногдуулан данслагдсан бэлтгэл офицер, цэрэг түрүүч, авто техникийн тодотголыг шинэчлэн боловсруулж авлаа.

Увс аймгийн засаг дарга болон төсвийн ерөнхийлөн захирагчийн хооронд бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтийн талаар байгуулсан гэрээний дагуу 2009 оны 06-р сард Түргэн суманд Цэргийн чухал мэргэжил бүхий 1-р зэргийн бэлтгэл үүрэгтэн 40 хүний сургалтыг зохион байгуулж явууллаа.

Гэрээнд заасан 4 ангийн 17 бүтээгдэхүүнийг 95 хувиар биелүүллээ.

3.1.7.Хууль зүй дотоод хэргийн Яам

Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнийг нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Аймгийн ГХУСА33-тэй хамтран мөн Хууль зүйн хэлтэс, холбогдох салбар зөвлөлөөр дамжуулан зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдалагаар хангаж ажилласны үр дүнд ард иргэдэд 165 удаа 16000 хүнд, цагдаагийн газрын тайлан тавьж, нийтийн эргүүлд 266 байгууллага 2350 хүнийг хамруулж, 85 удаа 21350 хүнийг сургалт, уулзалт өдөрлөг, уралдаан тэмцээнд хамруулж, орон нутгийн телевизээр 58 удаа, FM, радиогоор 68 удаа ухуулга сурталчилгааны зурагт хуудас 820, гарын авлага 250-ыг тарааж ажилласан байна.

Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнийг ажлаа хэвийн явуулхад нь анхаарч ажлын байр, ширээ , сандал, техник хэрэгсэл, компьютер зэрэг шаардлагатай материалаар байнга хангаж ажиллаж,одоогоор хөдөө сумдын хэсгийн төлөөлөгч нарын 5 кобаны барилга, 6 машин, 4 мотоцикль, унааны зардал, түлээ нүүрсээр хангасан. . Аймгийн засаг даргаас дэмжин Цагдаагийн газрын замын цагдаагийн тасагт Верна аксент маркийн авто машиныг иж бүрэн тоноглож хүлээлгэж өгсөн.

Жил бүр Аймгийн ГХУСА33, аймгийн Засаг дарга болон Цагдаагийн газрын даргын шийдвэр, хамтарсан шийдвэрээр аймгийн хэмжээнд нэгдсэн болон тусгай арга хэмжээг холбогдох байгууллагыг оролцуулан зохион байгуулж ажилладаг. 2009 онд Төр, захиргаа, хууль, мэргэжлийн хяналтын байгууллагуудтай хамтран Увс тойлуу, Баян цагаан зам, Зэл трейд, Хүрд оргил, Тоосгон уул, Мээрэнгийн ам, Бор хавцал зэрэг ХХК-уудад үзлэг шалгалт

явуулж 400 орчим хүн, 56 тээврийн хэрэгсэл, 80 орчим айл, гэр майхан зэргийг бүртгэлд оруулсан. Онцгой байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газартай хамтран Хотгор, Хар тарвагатай, Их тэмүүлэл, Эрдэс, Хүдэн зэрэг нүүрсний уурхайнууд, НИК болон хувийн шатахуун түгээх станцуудад шалгалт хийв. Архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн үйл ажиллагаанд хяналт тавих комиссоос / төрийн 5 байгууллага, ТББ-1 бүрэлдэхүүнтэй/ Улаангом сумын хэмжээнд архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж аттестатчилал явуулсанаар аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдах цэгийн тоог 50 хувь бууруулсан. Албан газар, аан байгууллагуудын удирдлагуудын хурал цуглаан дээр гэмт хэрэг, зөрчлийн мэдээ болон зарим байгууллага, албан тушаалтанд холбогдох зөрчлийг тухай бүр мэдээлж заншсан.

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх ажлыг эрчимжүүлж ажилласнаар 2009 онд 173.921.000 төгрөгний хохиролтой 115 холбогдогчтой малын хулгайн 81 эрүүгийн хэрэг илрүүлэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд 182.414.000 төгрөгний хохиролыг нөхөн төлүүлж ажиллав. Малын хулгайн гэмт хэрэг урьд оны мөн үеэс 33 хувиар өссөн боловч илрүүлэлт 96 хувьтай байна.

ЦЕГ-ын даргын 2006 оны 01 тоот албан даалгаварын хүрээнд галт зэвсгийн тухай хууль, ХЗДХ-ийн сайдын 223-р тушаалаар батлагдсан Галт зэвсгийн тооллого явуулах журам, ЦЕГ-ын даргын 2002 оны 39 тоот тушаалаар батлагдсан Галт зэвсгийг бүртгэх, гэрчилгээ олгох, улсын бүртгэлд оруулж хяналт тавих журмыг иргэд байгууллага, аж ахуйн нэгжүүдэд радио, телевиз, сонин хэвлэлээр сурталчлав. Харуул хамгаалалтын ажилтантай байгууллага аж ахуйн нэгжид үзлэг шалгалтыг 6 удаа хийж 52 бууг илрүүлж бүртгэлд хамруулав. Одоогоор нэгдсэн санд 1244 буу бүртгэгдэв

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагуудтай хамтран нэгдсэн ба тусгай арга хэмжээг 72 удаа зохион байгуулж, сургалт, уулзалт, өдөрлөг, уралдаан тэмцээн 72 удаа зохион байгуулж, 19900 иргэн хамрагдаж, зохиосон ажлаа орон нутгийн телевизээр 47 удаа, FM – ээр 44, төвийн “Хурд” радиогоор 10 удаа сурталчилгаа хийж, зурагт хуудас 627, санамж зөвлөгөө 7914 ш, сэрэмжлүүлэг 2612 ш – ийг хэвлүүлэн иргэдэд тараав. 2009 онд Увс аймгийн хэмжээнд хэв журмын нөхцөл байдалд үнэлэлт өгч, Улаангом сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд эргүүл, харуулыг өвөл, зуны байршилд шилжүүлэн, албан газар байгууллага, аж ахуйн нэгж, гэр хороололд 4 чиглэл маршрутаар явуулж, МУ-ын хуулиудыг сурталчилж, хийсэн ажлынхаа тайланг ард иргэдэд тавьж, тэднээс гарсан санал хүсэлт, шүүмжлэлийг хүлээн авч, түүний мөрөөр тодорхой ажил зохион явуулж, биелэлтийг тооцон ажиллалаа.

Увс аймгийн хэмжээнд “ Гэрээт харуул хамгаалалт”-ын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгж байхгүй болно. Харин энгийн харуул хамгаалалттай байгууллага аж ахуйн нэгжийн харуул хамгаалалтын байдалд Сонор-сэрэмж-1, 2 арга хэмжээнүүдийг зохион явуулж үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчлүүдийг арилгуулах зорилгоор 5 албан мэдэгдэл хүргүүлж, хариуг хугацаанд нь авч үр дүнг тооцон ажиллаа. Байгууллага, аж ахуйн нэгжийн харуул хамгаалалтын байдалд сар бүр шалгалт явуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллаж байна.

Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр *Шалгалт-2009*, Хяналт -1, 2, 3, Захирамж, Согтуу жолооч, Хорин тав, Спирт зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ

зохион байгуулав. Зурагт хуудас 450ш, санамж-160ш, сэрэмжлүүлэг -500ш тус тус тараан ажилласан. Архидан согтуурахтай тэмцэх хууль зөрчсөн 37 зөрчил илрүүлж, 5 албан тушаалтан, 6 аж ахуйн нэгж, 26 иргэнд 2153000 төгрөгний торгууль оногдуулж, 123 хүнийг шүүхээр баривчлуулж 1171 хүнийг эрүүлжүүлэв. Архины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршиг сэдвээр эрүүлжүүлэгдсэн, баривчлагдсан хүмүүст ухуулга яриа хийж цаашид архийг зөв зохистой хэрэглэх, гэр бүл хамт олон дотор, архидалтгүй орчинг бүрдүүлэхийг байнга сурталчилж байна. 2009 онд Архи согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх цэгийн үйл ажиллагаанд хяналт тавих комиссоос аймгийн төвд архи согтууруулах ундаа худалдаалдаг, түүгээр үйлчилдэг цэгүүдийн үйл ажиллагааг аттестатчилж үүний үр дүнд цэгүүдийн тоог 50 хувь бууруулаад байна. Архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх төрийн байгууллагуудад сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар 56 дугаар захирамж гарган мөрдүүлж ажиллаж байна.

Сайдтай байгуулсан гэрээний 5 ангийн 31 бүтээгдэхүүнийг 90 хувиар биелүүллээ.

3.1.8. Байгаль орчин аялал жуулчлалын Яам

Гэрээний дагуу аймгийн хэмжээнд 218 га талбайд ойжуулалт, 15 га–д Ногоон хэрмийн туслах зурвас төгөл байгуулах ажлын мэргэжлийн байгууллагууд гүйцэтгэлээ. Ойжуулалтын ажлыг Зүүнговь сумын Харбураа, Улаангом сумын Цагаан бураа, Тэрэм хад, Өндөрхангай сумын Могойн бэлчир, Сагил сумын Далт зэрэг газруудад хийсэн ба Ногоон хэрмийн туслах зурвасыг Наранбулаг, Завхан, Улаангом зэрэг сумдад хийж гүйцэтгэлээ.

Сангийн сайд, БО-ны сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Таримал ойг үнэлэн худалдан авах журам”-ын дагуу 5-6 жил арчлан ургуулж, экологийн хувьд ач холбогдол өгөх хэмжээнд хүрч, журмын шаардлага хангасан Улаангом сумын нутагт тарьж ургуулсан 14 иргэн аж ахуйн нэгжийн 57 га таримал ойг улсын ойн санд авахаар акт материалыг бүрдүүлэн Ойн газарт хүргүүлээд байна.

Улсын төсвийн хөрөнгөөр Ойн хайгуул ХК-ны ойн инженерүүдтэй хамтран Өндөрхангай, Цагаанхайрхан сумын ойн сангийн 1500 га талбайд ойн хөнөөлт шавьжтай тэмцэх тэмцлийн ажлыг химийн аргаар үүргийн шүршигч багажаар хийж гүйцэтгэлээ. Аймгийн Засаг даргын 2006 оны 356 тоот захирамжаар баталсан “Мод тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам”-ын дагуу мод тарьж ургуулсан иргэдийн материалыг бүрдүүлэн төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн бөгөөд гэрээний дагууд иргэн, байгууллагад 11 орчим сая төгрөгний модонд урамшуулал олгохоор байна.

Татварын албанаас авсан мэдээгээр 2009 оны төсөвт ойгоос 56582.8, ангаас 12597.0 ашигт малтмалаас 66481.4, уснаас 8749.5, газраас 61317.5, байгалийн дагалдах баялгаас 11725.5, ашигт малтмалын ашиглалтын лиценз 19460.3 хайгуулын лиценз 17941.6 буюу нийт дүнгээр 132099.7.0 мян/төг –ийг орон нутгийн төсөвт оруулаад байна.

Өндөрхангай сумын хөдөө аж ахуйн цаг уурын харуулыг цаг уурын өртөө болгон өөрчилж 4 хүнийг шинээр ажлын байраар хангаж, цалин хөлс, багаж, хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжид 34,5 сая төгрөг зарцуулсан байна. Гүний усны горимын судалгаа шинжилгээний ажлыг хийх зорилгоор улсын хөрөнгө оруулалтаар 6,8 сая төгрөгийн үнэтэй гүн өрмийн худаггаргаж ашиглалтаанд оруулж ажиллуулж байна. Сумдад ажиллаж байгаа хөдөө аж ахуйн цаг уурын харуулд зарим тоног төхөөрөмжийг хийж хэмжих хэрэгслэл байрлуулж нийт 880,0 мянган төгрөгийг зарцууллаа.

Увс-Бороо-Түргэн-1 экспедицийг 2009 онд ажиллуулсны үр дүнд Увс аймгийн нутгийн хойд хэсгээр 28%, өмнөд хэсгээр 12%, баруун хэсгээр 4%, зүүн хэсгээр 56%-иар тус тус хур тунадас нэмэгдүүлж ажиллалаа.

Шувууны томуу, хүний томуугийн цар тахалтай тэмцэх чадавхийг сайжруулах төслийн ажлын хүрээнд БОАЖГ-аас гаргасан төлөвлөгөөний дагуу мэдээллийг нэгтгэж танадалт судалгаа сургалт, сурталчилгааны хөтөлбөр гарган ажиллаж Увс, Хяргас, Хар-ус нууруудаар тандалт судалгаа хийж нууруудын ойролцоох нутгийн ард иргэд малчдад сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж нийт 11 сумын 29 багийн 3165 хүнд мэдээ мэдээллийг хүргэж, шувууны томуугуус урьдчилан сэргийлэх, болзошгүй аюулаас сэрэмжлүүлэх тухай анхааруулга санамж бүхий тараах материалл тараав.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Цөлжилттэй тэмцэх үндэсний хорооны санхүүжилтээр тус бүр нь 1,5 сая төгрөг, нийт 12.0 сая төгрөгийн өртөгтэй 8 булгийг Увс аймгийн Засаг даргын 149 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг явуулж Ногоон алт сан төрийн бус байгууллага шалгарч Увс аймгийн Түргэн, Тариалан, Сагил, Ховд, Хяргас, Малчин, Наранбулаг сумуудад Рашааны мухар /50°02'11", 91°38'24"/, Ааргийн зараа /49°41'14", 91°49'54"/, Хөх харгай /50°30'04", 91°20'01"/, Бага булаг /49°19'55", 90°48'10"/, Бэл булаг /49°26'04", 93°49'58"/, Хүрэн морьт /49°40'04", 93°20'51"/, Цүнхэг /49°38'10", 92°45'58"/, Хужиртын /49°29'52", 92°49'44"/ булгуудын эхийг хашиж хамгаалан хамгаалалтын бүсийн гортиг татаж, байгаль хамгаалах сурталчилгааны самбар байрлуулж, ойролцоо амьдардаг малчдад гэрээгээр хариуцуулан өгч ажиллав.

Сайдын гэрээний 4 ангийн 4 бүтээгдэхүүнийг 89 хувиар биелүүллээ.

3.1.9. Үндэсний статистикийн хороо

Үндэсний Статистикийн Хорооны даргатай байгуулсан гэрээний үүргээ биелүүлж тайлангийн хугацаанд 4 нэрийн бүтээгдхүүнийг нийлүүлж статистикийн албан ёсны мэдээ тайлан, тооллого судалгааг хугацаанд нь чанартай зохион байгуулан явуулж дүнг мэдээлж ирснээр ҮСХ-нд дамжуулах мэдээний теле дамжуулалт 100 хувь, үндсэн нэгжийн мэдээний ирц 96.4 хувьд хүрлээ.

Үндэсний Статистикийн Хорооноос баталж ирүүлсэн графикийн дагуу 14 хоног, сар, улирлын давтамжтайгаар нийтдээ 113 мэдээ тайланг тус хэлтэс хариуцан гаргаж, 30 мэдээ тайланг захиргааны мэдээлэл болгон авч нэгтгэн аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн дүнгийн тухай танилцуулга боловсруулж хэрэглэгчдэд тархаан танилцуулж ирснээс гадна эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2008 оны урьдчилсан дүнгийн танилцуулга, 2008 оны аймгийн ДНБ-ний тооцоо, өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа, ажиллах хүчний судалгаа, ажил эрхлэлтийн тайлан, түүний нэгтгэл, 2009 оны хагас, бүтэн жилээр мал тооллого зохион байгуулах, 2008 оны мал тооллогын дүнд боловсруулалт хийж танилцуулга бэлтгэх, мал бүхий 13.7 мянган өрхөөр мэдээллийн бааз бүрдүүлэх, аймгийн хэмжээнд 2008, 2009 оны жилийн эцсийн байдлаар өрх, хүн амын мэдээллийн сангийн бааз бүрдүүлэх зэрэг ажлыг ҮСХ-ны удирдамж, зааврын дагуу амжилттай зохион байгуулан явуулж үр дүнг хугацаанд нь хүргүүлж ирлээ.

2009 онд давхардсан тоогоор 3127 мэдээ, тайланг сум, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргуулан авахаас 3015 мэдээг хугацаанд нь авч, үндсэн газрын мэдээний ирц 96.4 хувьд хүрч мэдээний ирц өнгөрсөн оны мөн үеэс 2.9 пунктээр буурсан нь үндсэн нэгжид мэдээллийг хариуцан гаргадаг сум, багийн засаг дарга нарын 80- аад хувь нь өөрчлөгдсөнтэй холбоотой байна.

Сум, багийн түвшинд статистикийн мэдээ тайлан гаргалтын байдлыг сайжруулахын тулд сумдын орлогч дарга нарын сургалтыг 3 удаа зохион байгуулан явуулсан бөгөөд хүн амын мэдээллийн бааз бүрдүүлж дуусгах ажилд онцгойлон анхаарал тавьж ажилласны дүнд 2008 оны эцсийн өрх, хүн амын мэдээлэл 100 хувь мэдээллийн санд шивэгдэн орсон, 2009 оны мэдээллийг бүрдүүлэх шатандаа байна.

Гэрээний 4 ангийн 17 бүтээгдэхүүний хэрэгжилт 90 хувьтай байна.

3.1.10.Хүнс , хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн Яам

Хүнс, Хөдөө аж ахуйн салбарын төсвийн ерөнхийлөн захирагч ХХААХҮ-ийн сайд, Увс аймгийн засаг даргын хооронд 5 ангийн 621.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн худалдан авахаар талууд харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулсныг үндэслэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хүнс, хөдөө аж ахуйн салбарын зорилтуудыг хангуулах, зохицуулалт хийх, арга зүй, зохион байгуулалтын шуурхай удирдлагаар хангах үйл ажиллагааг явуулж бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайлан гаргаж дүн шинжилгээ хийн ажиллаж байна.

Аймгийн засаг дарга болон төсвийн ерөнхийлэн захирагчтай байгуулсан гэрээгээр баталсан орон тоогоор Аймгийн Хүнс, хөдөө аж ахуй жижиг, дунд үйлдвэрийн газрыг 14, мал эмнэлгийн албыг 9 орон тоотойгоор ажиллуулж, ажлаа жил, улирлаар төлөвлөн ажиллаж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн талаар гарсан Монгол улсын хууль, Засгийн газрын тогтоол, холбогдох шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх , дээрхи асуудлаархи аймгийн нэгдсэн бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх, мониторинг хийх, үнэлгээ өгөх, арга зүйн зөвлөлгөө өгөх, аймгийн ХХААЖДҮ-ийн газар, сум, байгууллагуудтай ажлаа уялдуулан зохицуулах, Засгийн газрын болон Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөбөр, 2009 оны аймгийн нийгэм эдийн засгийн зорилт, салбарын төсвийн ерөнхийлэн захирагчтай аймгийн Засаг даргын байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтын талаархи гэрээ, аймгийн Засаг даргын тамгын газрын төсвийн ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээг биелүүлэхэд ажлаа чиглүүлж ажиллаа.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, зах зээлийн хүрээг өргөтгөн, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн-10 , Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны – 12 заалт, аймгийн Засаг даргын нийгэм эдийн засгийн 2009 оны 8 зорилтыг тус тус хэрэгжүүлэхээр богино дунд хугацааны 12 хөтөлбөр, 4 төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2009 онд Европын холбоо, дэлхийн банкны “Тогтвортой амьжиргаа-2 “ төсөл, Дэлхийн зөн “Малчдын амьжиргааг дэмжих” төсөл,

Швейцарийн агентлагийн хөрөнгө оруулалттай Монгол дахь Мерси Кор “ Баруун бүсийн эдийн хөгжлийн бэхжүүлэх “ төсөл, “ Алтайн соёны экобүсийн уулархаг нутгийн биологийн төрөл зүйлийг ард иргэдийн оролцоотойгоор хамгаалах” төсөл хэрэгжиж байна.

ХХАА-н салбарын асуудлаар сумдын удирдлага, мэргэжилтэн, албадын төлөөллийг оролцуулан аймгийн зөвлөгөөн, семинар зохион байгуулж хэрэгжиж байгаа арга хэмжээ, тэдгээрийн үр дүн , алдаа доголдлыг дүгнэж, 2009 онд тавигдаж байгаа зорилтыг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж зөвлөмж чиглэл гаргаж ажилласан.

Аймгийн нийт хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо, сүргийн бүтэц, хээлтэгч малын эзлэх хувийн жинг сум бүрээр тооцон гаргаж холбогдох арга хэмжээг авч ажиллаа. Аймгийн дүнгээр нэг хээлтүүлэгчид ингэ- 19, гүү -9.2 , үнээ – 29.7, эм хонь –57.1 , эм ямаа-59.0 ноогдсон тохироотой байна. Сүрэгт хээлтэгч малын эзлэх хувийн жин ингэ –20.2%, гүү-30,9 %, үнээ – 28.6 %, эм хонь –42.8 %,эм ямаа – 47 %-д хүрч зохих хэмжээндээ байна. Аймгийн дүнгээр 19.9 мянган хээлтүүлэгч үзлэгт хамрагдаж нийт хээлтүүлэгчийн 9,1 % жишигт тэнцэж баталгаажлаа.

“ Малын эрүүл мэнд “ хөтөлбөрийн хүрээнд: 2009 онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд 1663.6 мян мал хамрагдсан.Паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 756.1 мянган толгой мал хамруулсан. Ариутгал халдваргүйтгэлийн арга хэмжээнг 348.8 мян м квадрат талбайд хийх ажлыг зохион байгууллаа.

ОХУ-д үржлийн мал гаргах ажлыг удирдан зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2009 оны 08-р сарын 17-ны өдрийн 334 тоот захирамжаар 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж,ОХУ-д мал экспортлох чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулж ОХУ-тай 2 удаа хэлэлцээр хийж , бүх сумдад чиглэл өгч ажиллаа.

“ Ус “ дэд хөтөлбөрийн хүрээнд: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр гаргах, сэргээн засварлах худгийн захиалгыг сумдаас авч нэгтгэн тендер шалгаруулж тендерт Энержи флоу констракшни,Ус- эрдэнэ ХК-ууд шалгарч 6-р асрын 01- ээс эхэлж үйл ажиллагаагаа явуулж инженерийн хийцтэй гүн өрмийн 15 ш инженерийн хийцтэй худаг шинээр гаргаж сумын Засаг дарга, малчид, малчдын бүлэгт хүлээлгэн өглөө.

Газар тариаланч,усжуулагчдын зөвлөгөөн зохион байгуулж газар тариалангийн үйлдвэрлэлийн техник, технологийн шинэчлэлийн талаар зөвлөлдөн ярилцсан. 2009 онд 2534-га-д үр тариа, 238.5 га-д төмс, 144.2 га-д хүнсний ногоо, 71 га-д жимс жимсгэнэ. 1200 га-д таримал тэжээл тариалж 3000 тн үр тариа,4245 тн –төмс, 3028 тн- хүнсний ногоо, 70 тн жимс жимсгэнэ ., 848тн тариамал тэжээл хураан авсан.Нийт тариалсан үр тарианы 90 % нь инженерийн хийцтэй услалтын сиситемд, 8.5 %-г гадаргуугын усалгаатай талбайд тариалсан. “Усалгаатай тариалан “ дэд хөтөлбөрийн хүрээнд : тариалангийн талбайг нэмэгдүүлэх зорилгоор Улаангом сум Улаантолгойд 108га,Түргэн сумын Хээр морьтод 10 га, Сагил Сумын Боршоон Сэнжид- 300 га инженерийн хийцтэй услалтын систем шинээр барих, Улаанхотгорын услалтын системийг сэргээн засварлах ажлууд хийгдэж улсын комисс 11эр сарын 12-14 ны өдрүүдэд ажиллаж ашиглалтанд хүлээж авсан.

“Ногоон хувьсгал “ үндэсний хөтөлбөрийн хүрээнд: 42 аж ахуйн нэгж 282 өрх хамрагдаж 471.6 га талбайд төрөл бүрийн таримал тариалж 675 тн ургац хураан авсан нь өнгөрсөн онтой харьцуулахад тариалсан талбай 92.4 га, өрхийн тоо-42, аж ахуйн нэгж “-аар нэмэгдэж хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, тариаланчдын амьжиргааг сайжруулах нөхцөл бий боллоо.Сумдаас жижиг оврын техник хэрэгслэл авах захиалга авч нэгтгэн ХХААЯаманд хүргүүлсэн. Ховд аймагт зохион байгуулагдсан Баруун бүс түншлэл-2009 үзэсгэлэн худалдаа, ХХААХҮЯ-ны өдрүүд, Олон улсын хөрөнгө оруулалтын чуулга уулзалтанд АЗДТГ, ХХААЖДҮГ, ХАҮТ-ын удирдлага, мэргэжилтнүүд болон 17 аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчдийн төлөөлөл,45 малчдын бүлэг нийт 100орчим хүний бүрэлдэхүүнтэй оролцож Улаангом сумын Ус-эрдэнэ ХХК-ийн чацарганы бүтээгдэхүүн Баруун бүсийн шилдэг экологийн бүтээгдэхүүн, Тариалан сумын” Алдар тулга, хоршоо шилдэгийг шилдэг аж ахуйн нэгжээр шалгарч, алтан медаль- 4, мөнгөн медаль- 5,хүрэл медаль- 4ш-г тус тус хүртсэн амжилт үзүүлсэн.

Суурин хүн амыг тэжээллэг чанар сайтаа, эрүүл ахуйн шаардлага хангасан, аюулгүй хүнсээр хангах улмаар экспортын чиг баримжаатай жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бүтээгдэхүүний стандарт боловсруулалтын түвшинг сайжруулах зорилгоор ЖДҮ-ийг дэмжих сангаас хүнсний үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид болон фермерийн аж ахуй эрхлэгчдэд 72 иргэн аж ахуйн нэгжид 770.2 сая төгрөгний зээл олгох ажлыг зохион байгууллаа.

“Увс түншлэл – 2009” үзэсгэлэн худалдааг “ Үйлдвэрлэлээ өргөжүүлье “ уриан дор АЗДТГ, Худалдаа аж үйлдвэрийн танхим, Мерси кор төсөл хамтран зохион байгуулж, ХХАА-н бүтээгдэхүүн, гар урлал, бэлэг дурсгал, аж үйлдвэр, барилгын материал зэрэг 11 номицаар шалгаруулж тус бүрт алт, мөнгө, хүрэл медаль, диплом мөнгөн шагнал олгож орон нутгийн радио телевизороор сурталчилсан. Энэ арга хэмжээнд 12 сумын 82 иргэн, аж ахуйн нэгж, 3 төсөвт байгууллага 268 нэрийн бүтээгдэхүүнээр оролцсон.

Гэрээний 5 ангийн 16 бүтээгдэхүүнийг 89 хувиар биелүүллээ.